

[illegible][illegible]

Уг тайланг боловсролын эсвэл ашгийн бус зорилгоор бүтнээр болон хэсэгчлэн дахин ашиглаж болох бөгөөд ингэхдээ зохиогчдоос тусгай зөвшөөрөл авах шаардлагагүй хэдий ч эх сурвалжийг зайлшгүй дурдах шаардлагатай. НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрийн ажлын албанд тухайн ашигласан материалыг хүргүүлбэл талархах болно.

НҮБ-ын БОХ-өөс урьдчилан зөвшөөрөл авалгүйгээр тайланг ашиг олох үйл ажиллагаанд буюу худалдаалахыг хориглоно.

САНАМЖ

Тайлангийн зохиогчид болон судалгааны агуулга, мэдээллүүд нь НҮБ-ийн Ерөнхий нарийн бичгийн даргын зүгээс аль нэг улсын хууль эрх зүйн статус, нутаг дэвсгэр, хот суурин болон түүний харьяа газрууд, хил хязгаарын холбогдолтой аливаа үзэл санааг илэрхийлээгүй болно. Түүнчлэн, энэхүү тайлангийн агуулга нь НҮБ-ийн Байгаль орчны хөтөлбөрийн шийдвэр эсвэл бодлогын байр суурийг илэрхийлээгүйн зэрэгцээ тайланд дурдагдаж буй аливаа нэрс, худалдааны үйл ажиллагаа нь сурталчилгааны зорилгогүй болно.

НОГООН ЭДИЙН
ЗАСГИЙН
БОДЛОГЫН
ҮНЭЛГЭЭ:
**МОНГОЛ
УЛСЫН НОГООН
ХӨГЖЛИЙН
БОДЛОГЫН
ХЭРЭГЖИЛТ**

ДУНД ХУГАЦААНЫ ТОЙМ

ТАЛАРХАЛ


Энэхүү тайланг НҮБ-ийн Байгаль орчны хөтөлбөр болон Байгаль орчин, аялал жуулчлалын яамны хүсэлтийн дагуу Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв (Ихбаярын Одончимэг, Гончигсумлаагын Ганзориг, Батцолмонгын Мөнгөнжигүүр)-ийн зүгээс бэлтгэсэн болно. Энэхүү тайланг “Тогтвортой хөгжлийн зорилтуудын хүрээнд хүртээмжтэй ногоон эдийн засгийн бодлого боловсруулах” төслийн хүрээнд Европын холбоо санхүүжүүлж НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрөөс боловсруулсан ногоон эдийн засгийн бодлогыг хянах арга зүйд үндэслэсэн болно. Тус тайлангийн зохицуулагчаар НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрийн Нөөц ба зах зээлийн газрын Клаудиа Ассманн ажиллаж, Фулай Шенг, Стивен Стоун нар чиглэл өгсөн. Түүнчлэн НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрөөс Жозеф Прайс, Анна-София Элм нар тайлантай танилцаж, эцэслэхэд туслав.



Европын холбоо санхүүжүүлэв.



БАЙГАЛЬ ОРЧИН
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



ECONOMIC POLICY AND COMPETITIVENESS
RESEARCH CENTER

ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО, ӨРСӨЛДӨХ
ЧАДВАРЫН СУДАЛГАНЫ ТӨВ

АГУУЛГА

Хүснэгтийн жагсаалт	v
Зургийн жагсаалт	v
Товчилсон үгсийн жагсаалт	vii
Хураангуй	viii
1. Удиртгал	1
1.1. Ногоон хөгжлийн бодлого	2
НХБ-ын шалгуур үзүүлэлт	3
Ногоон хөгжлийн бодлогын шалгуур үзүүлэлтийг бусад бодлогын хэрэгжилтийн шалгуур үзүүлэлтүүдтэй харьцуулсан нь	4
1.2. Үнэлгээний арга зүй, хамрах хүрээ	4
2. Бодлогын хэрэгжилтийн үнэлгээ	7
2.1. Бодлого боловсруулах үйл явц	7
2.2. Бодлогын хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	9
2.3. НҮБ -ын тогтвортой хөгжлийн зорилтууд болон үндэсний бодлогын баримт бичгийн уялдаа	10
2.3.1. Алсын хараа - 2050	10
2.3.2. Тогтвортой хөгжлийн зорилтууд	13
2.4. Шалгуур үзүүлэлтийн биелэлт	14
3. Дүгнэлт, зөвлөмж	21
4. Ашигласан материалын жагсаалт	23
5. Хавсралт	26
5.1. Ярилцсан хүмүүсийн жагсаалт	26
5.2. Уншиж танилцсан баримт бичгийн жагсаалт	27
5.3. Тогтвортой хөгжлийн зорилгын биелэлт	27
5.4. "Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал - 2030" бодлогын биелэлт	29
5.5. "Ногоон хөгжлийн бодлогын хэрэгжилт" хэлэлцүүлгийн үеэр гарсан санал	31

Зургийн жагсаалт

Зураг 1. Ногоон хөгжлийн бодлогын шалгуур үзүүлэлтийн биелэлт	18
--	----

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Ногоон хөгжлийн бодлогын шалгуур үзүүлэлтүүд	3
Хүснэгт 2. Бодлого боловсруулах үйл явцын он цагийн товчоо	7
Хүснэгт 3. Зөрүүтэй байдлаар тодорхойлогдсон шалгуур үзүүлэлтүүд	13
Хүснэгт 4. Монгол улсын ногоон хөгжлийн бодлогын хэрэгжилтийн үнэлгээ: 14 шалгуур үзүүлэлтийн биелэлт	15
Хүснэгт 5. Ярилцсан хүмүүсийн жагсаалт	26
Хүснэгт 6. Тогтвортой хөгжлийн зорилгын биелэлт	27
Хүснэгт 7. "Тогтвортой хөгжлийн зорилго-2030" урт хугацааны хугацааны хөгжлийн баримт бичгийн .. биелэлт	29
Хүснэгт 8. Ногоон хөгжлийн бодлогын хэрэгжилт хэлэлцүүлгийн үеэр гарсан санал	31



ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

АНУ	Америкийн нэгдсэн улс	ТББ	Төрийн бус байгууллага
АХБ	Азийн Хөгжлийн Банк	ТОС	Монголын тогтвортой санхүүжилтийн холбоо
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилтууд
БОНХЯ	Байгаль орчин, ногоон хөгжлийн яам	ТХҮБ 2030	МУ-ын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал - 2030
БОСҮ	Байгаль орчны стратегийн үнэлгээ	ТХХТ	Төр хувийн хэвшлийн түншлэл
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам	УАӨСК	Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенц
ГОУХАН	Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг	УАӨҮХ	Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн	УИХ	Улсын их хурал
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэр	УУХҮЯ	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
ЗТХЯ	Зам, тээврийн хөгжлийн яам	ҮСХ	Үндэсний статистикийн хороо
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар	ҮТХН	Үндэсний тодорхойлсон хувь нэмэр
МУИС	Монгол Улсын их сургууль	ҮХГ	Үндэсний хөгжлийн газар
МУХАҮТ	Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим	ХААИС	Хөдөө аж ахуйн их сургууль
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	ХХ	Хүлэмжийн хий
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага	ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
НҮББОХ	НҮБ-ын байгаль орчны хөтөлбөр	ШУТИС	Шинжлэх ухаан технологийн их сургууль
НҮБХХ	Нэгдсэн үндэстний байгууллагын Хөгжлийн хөтөлбөр	ЭЗБӨЧСТ	Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв
НХБ	Ногоон хөгжлийн бодлого	ЭХЗХ	Эрчим хүчний зохицуулах хороо
НЭЗТТ	Ногоон эдийн засгийн төлөөх түншлэл	СО2	Нүүрстөрөгчийн давхар исэл
ОУВС	Олон улсын валютын сан		
СЭХҮТ	Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв		



Хураангуй

Монгол Улс Ногоон хөгжлийн бодлогыг (НХБ) 2014 онд соёрхон баталсны дараагаар ногоон хөгжлийн үндэсний бодлоготой болсон анхдагч улсуудын нэг болов. НХБ батлагдсанаар Монгол Улс ногоон эдийн засагт шилжих эрмэлзэлтэй байгааг илэрхийлж буй явдал юм. Улмаар Монгол Улсаас туршлага судлах сонирхлыг төрүүлж, хамтын ажиллагааны санаачилгыг хэрэгжүүлэх замаар дотоодын бодлого, шийдвэр гаргагчид болон хувийн хэвшлийн төлөөллүүдэд ногоон эдийн засгийн талаар илүү сайн ойлгон, хүлээн авахад тусалсан юм.

2020 оны их хурлын сонгуулийн өмнө Монгол Улсын их хурал (УИХ) “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг баталсан. Ингэснээр 2016 онд баталсан өмнө нь хэрэгжиж байсан Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 хүчингүй болсон ч НХБ хүчин төгөлдөр хэвээр үйлчилж байна. 2020, 2030 онд хүрэх үр дүнгийн эхний үе шат 2020 онд дууссан тул бодлогын хэрэгжилтийн явцыг энэхүү шатанд үнэлсэн болно.

НХБ нь “Алсын хараа-2050” (2020), “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030” (2016), НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилтууд (ТХЗ), Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль (УИХ, 2015) зэргийг соёрхон батлагдахаас өмнө батлагдсан тул НХБ-ыг бусад бодлогын баримт бичигтэй уялдуулах талаар эргэн харах нь нэн чухал юм.

Энэхүү судалгаанд НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр (НҮББОХ)-өөс боловсруулсан ногоон эдийн засгийн бодлогын үнэлгээний аргачлалын дагуу ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой бодлогын арга хэрэгсэл буюу УИХ-аас баталсан хууль, Монгол Улсын Засгийн газрын (МУЗГ) тогтоол, үйл ажиллагааны төлөвлөгөө, сайдын тушаал болон бусад судалгаа, бодлогын баримт бичгүүдийн тоймыг багтаасан болно. Мөн тусгай сан, төрийн бус байгууллага (ТББ)-ын оролцоо, мэргэжлийн холбоодын дэмжлэг төр-хувийн хэвшлийн түншлэл (ТХХТ) зэргийг оруулав.

Тайлангийн эхний бүлэгт НХБ, цар хүрээ түний зорилт болон шалгуур үзүүлэлт, судалгааны аргачлалын талаар танилцуулсан бол 2-р бүлэгт бодлогын хэрэгжилтийн үнэлгээ тэр дундаа НХБ-ын хэрэгжилтийн явц, үүнд 1) 2020 оны зорилтод хүрсэн эсэх талаар дүн шинжилгээ хийх 2) НХБ нь ТХЗ болон “Алсын хараа-2050” урт

хугацааны хөгжлийн бодлоготой хэрхэн уялдаж байгааг ойлгох 3) 2019 оны 12 сард зохион байгуулсан ярилцлага, хэлэлцүүлгийн үр дүнг нэгтгэх, 3-р бүлэгт дүгнэлт, зөвлөмжийг тусгасан болно.

Дунд хугацааны хэрэгжилтийг 2020 оны зорилттой харьцуулсан дүн шинжилгээнд хэмжих боломжтой 10 шалгуур үзүүлэлтээс долоо нь 70-аас дээш хувийг хангаж, үүнээс дөрөв нь зорилтот түвшнийхээ 90 гаруй хувьд хүрсэн байна. Өөрөөр хэлбэл НХБ-ын хэрэгжилтийг “дунджаас дээгүүр” гэж дүгнэж болохоор байна. Бодлогын хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх бодлогын хэрэгслүүдийн тоо хангалттай сайн бөгөөд НХБ болон “Алсын хараа-2050”, ТХЗ-ын хоорондын уялдаа харьцангуй өндөр байгааг судлаачид олж тогтоожээ. Иймд төслийн баг НХБ нь хүчин төгөлдөр хэвээр байгаа хэдий ч соёрхон баталсны дараа баталсан хууль тогтоомж, үндэсний урт хугацааны бодлогын баримт бичгүүдтэй илүү нийцүүлэхийн тулд нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчлэх нь үр дүнтэй гэж үзэж байна. Ингэхдээ боломжит өгөгдөл болон бусад урт хугацааны зорилго, зорилтуудад үндэслэн шалгуур үзүүлэлт, зорилтууд, түүнд хүрэх арга замыг шинэчилж болно.

Гэхдээ судалгааны явцад хийсэн ярилцлага, хэлэлцүүлгийн үр дүнгээс харахад төрийн байгууллагууд хоорондын уялдаа холбоо хангалтгүй, нэгдсэн ойлголт сул байгаа нь анзаарагдаж байв. Тухайлбал судалгааны явцад хийсэн ярилцлага, уулзалтуудын үеэр НХБ-д БОАЖЯ-наас бусад яамд, агентлагууд хангалттай ач холбогдол өгөхгүй байгаа нь ажиглагдав. Мөн ажил хариуцсан төрийн албан хаагчид сонгуулийн дараа ихээр өөрчлөгддөг нь бодлогын хэрэгжилтэд саад болж байна. Түүнчлэн төрийн байгууллагууд нүүрстөрөгчийн давхар исэл (CO2) ялгаруулалтыг хэрхэн хэмжих талаар нийтлэг ойлголтоо сайжруулах хэрэгтэй гэж үзэж байна¹.

Судалгааны үеэр зарим үзүүлэлтүүдийн өгөгдөл байгаагүй тул НХБ-ын хэрэгжилтийг үнэлэх нь зарим талаар хүндрэлтэй байсан. Жишээлбэл, зарим суурь өгөгдөл байхгүй тул гүйцэтгэлийг үнэлэхэд бэрхшээлтэй байв. Мөн 2014 онд хуулийн төсөл боловсруулах үйл явц харьцангуй хялбар байсан бөгөөд ТХЗ-ыг хараахан батлаагүй байсан зэргийг харгалзан үзэх шаардлагатай юм. Нөгөө талаас, Монгол Улсын Хөгжлийн бодлогын тухай хуулийн дагуу аливаа бодлогын баримт

1 Ярилцлагын ажиглалт

бичиг боловсруулахад тавигдах стандарт, шалгуур үзүүлэлтүүдэд суурь судалгаа, нөлөөллийн дүн шинжилгээ, мэдээллийн бэлэн байдлыг шаарддаг.

Судалгааны үр дүн, зөвлөмжийг нэгтгэн дүгнэвэл:

- НХБ-ыг Монгол Улсын Хөгжлийн бодлогын тухай хууль болон бусад бодлогын баримт бичигтэй уялдуулан шинэчлэхдээ анхааралтай хандах хэрэгтэй. Учир нь бодлогын шинэчлэлтэй холбоотой батлагдах журам, тушаалууд нь үйл ажиллагаа, санаачилга, болон төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд нөлөөлж болзошгүй юм;
- НХБ, зорилтот түвшинд хүрэхийн тулд ногоон хөгжил, судалгаа шинжилгээ, технологийн салбарт хөрөнгө оруулах Дотоодын нийт бүтээгдэхүүний (ДНБ) хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай бөгөөд ингэснээр урт хугацаанд нийгэм, эдийн засагт эерэг үр өгөөж авчрах болно;
- Оролцогч талуудын дунд нийтлэг ойлголтыг бий болгож тогтвортой дүрэм, журам тогтоох нь чухал билээ. Тодруулбал, МУЗГ-ын оновчтой зохион байгуулалт, байнгын үйл ажиллагаатай мэдээлэх платформ болон хамтарсан ажлын алба байгуулснаар төрийн байгууллагуудын хоорондын уялдаа холбоо сайжрах юм;

- Барилга, аялал жуулчлал, хүнсний үйлдвэрлэл, хөдөө аж ахуй зэрэг салбаруудтай хамтран ажиллах замаар банкны салбарын сайн туршлагыг дэлгэрүүлж ТХХТ-ийг бэхжүүлэх шаардлагатай;
- Уул уурхай, үйлдвэрлэл, барилга, худалдаа зэрэг салбарт ногоон стандартыг хэрэгжүүлснээр НХБ, зорилтот түвшинд хүрэхэд эерэг нөлөө үзүүлэх боломжтой;
- Байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгжүүдийг урамшуулах нь НХБ-ыг хэрэгжүүлэх ашигтай хэрэгсэл болно. Ингэхдээ урамшууллын шалгуурыг ил тод, тодорхой байлгах ёстой;
- Төрийн албан хаагчийн ажлын байрны тодорхойлолтод ногоон үүргийг тусгаж, албан тушаал дэвших, шагнал олгох асуудлыг авч үзэхдээ нэг шалгуур болгон оруулах нь зүйтэй;
- Иргэд болон аж ахуйн нэгжид ногоон боловсрол олгох замаар ногоон эдийн засагт хандах олон нийтийн хандлага, мэдлэгийг дээшлүүлэх;
- Бодлого төлөвлөлт, хэрэгжүүлэх үйл явцад олон улсын болон дотоодын ТББ, судалгааны төвүүдийн оролцоог нэмэгдүүлэх нь үр ашигтай байж болно;





1. Удиртгал

Энэхүү судалгааны зорилго нь 2014 онд УИХ-аар батлагдсан НХБ-ын дунд хугацааны хэрэгжилтийг үнэлэхийн зэрэгцээ тус бодлого нь үндэсний болон олон улсын хэмжээний бодлого хөтөлбөрүүдтэй хэрхэн нийцтэй байгааг судлах явдал юм. Тус судалгааг НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрөөс 2020 онд боловсруулсан бодлогын үнэлгээний аргачлалын дагуу хийж гүйцэтгэв.


Одоогоор НХБ-ын хэрэгжилтийг аль нэг байгууллагын зүгээс үнэлж, дүгнээгүй байна. БОАЖЯ-ны ногоон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газар “Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийн тайлан”-г 2018, 2019 онд тус тус гаргасан. Гэхдээ энэхүү тайланд ногоон хөгжлийн бодлогын хэрэгжилтийн явцын үнэлгээ хийгээгүй, харин зорилт, арга хэмжээ тус бүрээр хийгдсэн ажил, баталсан эрх зүйн баримт бичгүүдийг оруулсан байна.²

НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн захиалгаар Ногоон эдийн засгийн төлөөх түншлэл (НЭЗТТ) санаачилгын зүгээс хэвлүүлсэн “Ногоон эдийн засгийн явцын хэмжилтийн хүрээний хэрэгжилт, дэлхий дахинаа ядуурлыг арилган нэгдсэн хөгжил дэвшилд хүрэхэд чиглэсэн улс орнуудын явцыг үнэлэх нь” тайланд Монгол Улсын ногоон эдийн засагт шилжих явц судалгаанд хамрагдсан бусад орнуудтай харьцуулахад хамгийн сүүлийн байранд орсон байна (НЭЗТТ 2017).

НЭЗТТ -ийн захиалгын дагуу Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвийн зүгээс 2018 онд “Ногоон эдийн засгийн бодлогын дүн шинжилгээ: Монгол Улс” үнэлгээний тайланг боловсруулан гаргасан ба энд Монгол Улсын ногоон хөгжлийн бодлогын хэрэгжилтийг үнэлэх талаар дурдаж, Т21³ загвар ашиглан ногоон эдийн засгийн чиглэлээр хийх хөрөнгө

оруулалтыг нэмэгдүүлснээр НХБ болон ТХЗ-ууд хэрхэн хангагдах боломжтой болохыг тооцон оруулсан.

Монгол Улс ногоон хөгжлийн бодлоготой болсон нь дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлагатай нэгдэж байгаль орчинд ээлтэй, ирээдүй хойч үедээ эрүүл амьдрах орчныг өвлүүлэн үлдээх гэсэн эрмэлзлийн үр дүн юм. Тайлангийн энэ хэсэгт НХБ, түүний шалгуур үзүүлэлтүүд болон судалгааны арга зүйг дор тайлбарлав.



2 2018 оны тайланд 2017, 2018 оны, 2019 оны тайланд 2018, 2019 оны ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг тус тус оруулжээ.

3 Threshold 21 буюу Т21 загвар нь урт хугацааны, цогц, нэгдсэн төлөвлөлтийг дэмжих, динамик тооцоолол хийх боломжтой загвар юм. Т21 загварт нийгэм, эдийн засаг, хүрээлэн буй орчин зэрэг хүчин зүйлүүдийг нэгтгэсэн тул салбарын хөгжлийн бодлогуудын хоорондын уялдааг харахаас гадна зорилго, зорилтууд хэрхэн биелэхийг таамаглах боломжтой. Монгол Улсын Т21 загварт эрдэс баялгийн салбарын орлого, нийт экспортын ашиг мөн эрдэс баялгийн бүтээгдэхүүний үнийн нөлөөллийг нэмж тусгаж өгсөн.

1.1. Ногоон хөгжлийн бодлого

УИХ-ын 2014 оны 6-р сарын 13-ны өдрийн 43 дугаар тогтоолоор “Ногоон хөгжлийн бодлого”⁴-ыг баталсан нь Монгол Улс анх удаа тэгш хүртээмжтэй ногоон эдийн засаг, ногоон хөгжлийн бодлогын баримт бичиг баталсан түүхэн үйл явдал болсон. Тус бодлогын дагуу УИХ-аас МУЗГ-т нэгдүгээрт бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусган хэрэгжүүлэх, хоёрдугаарт тус бодлогод тусгагдсан зорилго, зорилт, хэрэгжүүлэх арга замыг үндэсний хөгжлийн бодлого, макро эдийн засгийн дунд хугацааны бодлого, чиглэлд тусган хэрэгжүүлэх, гуравдугаарт тус бодлогын биелэлтийг жил бүр УИХ-д танилцуулж байх гэсэн гурван цогц арга хэмжээг даалгасан байна.

Байгаль орчин, ногоон хөгжлийн яам (БОНХЯ, одоогоор БОАЖЯ) -аас анх санаачлан УИХ-ын холбогдох байнгын хороодын дэмжлэгтэйгээр НХБ-ын баримт бичиг нь 2014 онд албан ёсны эрх зүйн баримт бичиг болсон.

НХБ-ын нь “Ногоон хөгжлийн үзэл санаанд тулгуурласан, иргэдийн оролцоог хангасан эдийн засгийн өсөлтийг бий болгосноор хүрээлэн байгаа орчны тогтвортой байдлыг хадгалан ирээдүй хойч үедээ өвлүүлж, үр өгөөжийг нь урт хугацаанд хүртэх боломжоор хангах нөхцөлийг бүрдүүлсэн хөгжингүй улс” болгох үндсэн зорилготой (УИХ, 2014). Энэхүү зорилгын хүрээнд нийт 6 стратегийн зорилтыг дэвшүүлсэн. Үүнд:

- 1.1.** Байгалийн нөөцийн хэмнэлттэй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай үйлдвэрлэл, хэрэглээг хөгжүүлнэ;
- 1.2.** Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэн орчны бохирдол, доройтлыг бууруулж, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгална.
- 1.3.** Ногоон эдийн засгийг дэмжих санхүүжилт, татвар, зээл, урамшууллын оновчтой хөшүүргийг нэвтрүүлж, байгаль хамгаалал, хүний хөгжил, цэвэр технологийг дэмжих хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.

⁴ Тус бодлогын баримт бичгийн төсөл нь “Ногоон хөгжлийн үзэл баримтлал” гэсэн томъёоллоор УИХ-д өргөн баригдсан боловч хэлэлцүүлгийн явцад “Ногоон хөгжлийн бодлого” болж өөрчлөгдсөн болно. (Ажлын хэсгийн гишүүн)

1.4. Ногоон ажил эрхлэлтийг дэмжиж, ядуурлыг бууруулан ногоон амьдралын хэв маягийг төлөвшүүлнэ.

1.5. Байгальд зохицсон ахуй, соёлын үнэт зүйлсийг хөгжүүлж, боловсрол, шинжлэх ухаан, технологи, инновацийг ногоон хөгжлийн хурдасгуур болгоно.

1.6. Уур амьсгалын өөрчлөлт, бүс нутгийн байгалийн нөөц баялаг, сэргэх чадавхад нийцүүлэн хүн амын суурьшлыг төлөвлөн хөгжүүлнэ.

Ногоон хөгжлийн бодлогыг хоёр үе шаттай хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Эхний үе шатанд (2014-2020 он) ногоон хөгжлийн үндсийг тавих бөгөөд Монгол Улсын нөхцөлд тохирсон ногоон хөгжлийн загвар, хэм хэмжээг эдийн засаг, нийгмийн бүхий л салбарт бий болгож, ногоон хөгжлийг хангахад чиглэсэн эрх зүйн орчныг бүрдүүлж, эдийн засгийн урт хугацааны тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн дэд бүтэц, бүтээн байгуулалтын ажлыг идэвхтэй өрнүүлснээр Монгол Улсын тогтвортой хөгжлийн зорилгыг хэрэгжүүлж, бүс нутагтаа өрсөлдөх чадвар бүхий үйлдвэрлэл, үйлчилгээний салбар хөгжиж, мэдлэгт суурилсан эдийн засаг төлөвшиж, ногоон хөрөнгө оруулалт, санхүүжилтийн механизмаар байгальд ээлтэй, үр ашиг өндөртэй ногоон дэд бүтэц, сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэл, цэвэр үйлдвэрлэлийн технологийг хөгжүүлж, нэгж бүтээгдэхүүнд ногдох хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахаар тусгасан байна.

Хоёрдугаар үе шатыг (2021-2030 он) Ногоон хөгжилд шилжих шилжилтийн үе гэж тодорхойлсон. Энэ хугацаанд байгаль орчны тогтвортой байдлыг хадгалж, экосистемийн үйлчилгээний үр өгөөжийг ухаалгаар хүртэж, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, өндөр үр ашигтай ногоон эдийн засаг, нийгмийн тэгш хүртээмжтэй тогтолцоо төлөвшсөн байна. Мөн түүнчлэн эдийн засгийн суурь бүтцэд өндөр технологи, инноваци шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл давамгайлж, улмаар ногоон эдийн засагт шилжинэ.

МУЗГ-ын 2016 оны 1-р сарын 11-ний өдрийн 35 дугаар тогтоолоор “Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-г баталсан байна. Тус баримт бичигт зорилт тус бүрийг хэрэгжүүлэх арга замуудыг тодорхойлж, ач холбогдлоор нь эрэмбэлэн, хэрэгжүүлэх үйл ажиллагааг харгалзах хугацааны хамт төлөвлөжээ. Үүний тулд үндсэн болон хамтран хэрэгжүүлэх байгууллагыг оноож өгсөн байна. Үүнд засгийн газрын яамд, агентлагууд, орон нутгийн засаг

Хүснэгт 1. Ногоон хөгжлийн бодлогын шалгуур үзүүлэлтүүд

#	Шалгуур үзүүлэлт	Зорилт 2020 (%)	2030 (%)
1	Эрчим хүчний суурилагдсан хүчин чадалд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувь	20	30
2	Барилгын дулааны алдагдлын бууралт, хувь	20	40
3	Хог хаягдлын дахин боловсруулалтын хэмжээ, хувь	20	40
4	Ногоон хөгжилд зарцуулах зардлын ДНБ-д эзлэх хувь	2	3
5	Шинжлэх ухаан, технологийн судалгаанд зарцуулах зардлын ДНБ-д эзлэх хувь	2	3
6	Засгийн газрын ногоон худалдан авалтын эзлэх хувь	20	30
7	Тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ, хувь	25	30
8	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх хувь	20	30
9	Нийт газар нутагт ойгоор бүрхэгдсэн талбайн эзлэх хувь	8.5	9
10	Баталгаат ундны усаар хангагдах хүн амын эзлэх хувь	80	90
11	Сайжруулсан ариун цэврийн байгууламжид хамрагдах хүн амын эзлэх хувь	40	60
12	Ядуурлын түвшин	24	15
13	Улаанбаатар хот, бусад суурин газрын ногоон байгууламжийн талбайн эзлэх хувь	15	30
14	ДНБ-д ХАА, боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хувь	28	30

Эх сурвалж: УИХ, 2014

захиргаа, МҮХАҮТ, компаниуд багтсан болно. Мөн арга хэмжээ тус бүрээр хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт зэргийг тогтоож өгчээ.

НХБ-ын шалгуур үзүүлэлт

Зургаан стратегийн зорилго тус бүрээр шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлсон бөгөөд эдгээрийн зарим нь тодорхой тоогоор илэрхийлэгдэж байхад, зарим нь илүү чанарын үзүүлэлтэд түшиглэсэн. Тэдгээр шалгуур үзүүлэлт нь тус бодлогын баримт бичгийн салшгүй нэг хэсэг юм. Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлснээр 2020, 2030 онд хүрэх үр дүнг доорх 14 шалгуур үзүүлэлтээр хэмжихээр тусгагдсан.

НХБ-ын баримт бичигт 2013 оны тоон мэдээллийг суурь болгон авч үзнэ гэж заасан боловч үзүүлэлт тус бүрд суурь оны тоон мэдээлэл хэд байсныг оруулалгүй,

харин 2020, 2030 онд хэд болох зорилтыг оруулж өгсөн нь судлаачдын дунд эргэлзээ төрүүлж байна.⁵ Үүнийг тайлангийн 1.2 Үнэлгээний арга зүй, хамрах хүрээ бүлэгт дэлгэрэнгүй тайлбарлах болно.

НХБ-ын хэрэгжилтийн хувьд эхний үе шатанд байгаа бөгөөд биелэлтийг тоон үзүүлэлтээр харахад хангалтгүй үзүүлэлттэй байна. Гэвч Үндэсний статистикийн хорооноос (УСХ) тогтвортой хөгжлийн шалгуур үзүүлэлт гарган, шалгуур үзүүлэлт тус бүрийн гүйцэтгэлийг 2015 оноос хойш үнэлж, олон нийтэд зарлаж байна (УСХ, 2020).

Ногоон хөгжлийн бодлогын шалгуур үзүүлэлтийг бусад бодлогын хэрэгжилтийн шалгуур үзүүлэлтүүдтэй харьцуулсан нь.

Энэхүү судалгааны ажлын хүрээнд ногоон хөгжлийн бодлогын дэлхийн тогтвортой хөгжлийн зорилготой нийцэж буй эсэхэд үнэлгээ өглөө. НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 70 дугаар чуулганаас тогтвортой хөгжлийн 17 зорилго, 169 зорилт бүхий баримт бичгийг баталж,

5 2020 оны 6-р сарын 13-нд УИХ-д өргөн барьсан бодлогын баримт бичигт 2013 оны зарим суурь шалгуур үзүүлэлтүүдийг тусгасан байсан. Гэвч урьдчилсан хэлэлцүүлгийн үеэр бусад шалгуур үзүүлэлт байхгүй гэсэн шалтгаанаар тэдгээр шалгуур үзүүлэлтийг хассан гэж ярилцлагад оролцогчид тэмдэглэжээ.

2016 оны 01-р сарын 01-нээс дэлхий нийтээр хэрэгжүүлж эхэлжээ. Түүнчлэн, 2017 оны хавар НҮБ-ын Статистикийн хорооны чуулганаар дээрх зорилгын хэрэгжилтийг үнэлэх 244 шалгуур үзүүлэлтийг боловсруулж, баталсан. Монгол Улс нь ТХЗ-ыг хэрэгжүүлсэн анхдагч улсуудын нэг болсон бөгөөд “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” (ТХҮБ 2030) үндэсний бодлогын баримт бичгийг 2016 баталсан боловч 2020 оны 5 дугаар сард “Алсын хараа-2050” урт хугацааны, илүү нарийвчилсан хөгжлийн бодлогыг баталснаар “ТХҮБ 2030”-ыг хүчингүй болгосон.

ҮСХ-ноос 2015 онд Монгол Улсын хувьд тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтийг үнэлэх боломжтой үзүүлэлтийн талаар санал өгч байжээ. Үүнд, гаргах боломжтой буюу бэлэн байгаа 45 (17.5%), бага зэрэг тооцоолол хийсний дараа гаргах боломжтой 64 (24.9%), тооцоолол нэлээд хийсний дараа гаргах боломжтой 28 (10.9%), ОУ-ын байгууллагаас гарах 5 (1.9%), мэдээллийн эх үүсвэр бий болгох, эх үүсвэрт өөрчлөлт оруулах 72 (28.0%), огт гарахгүй 43 (16.7%) үзүүлэлт байна гэж үзжээ. Цаашилбал тогтвортой хөгжлийн зорилгын нарийвчилсан шалгуур үзүүлэлтийн 60%-ийг мэдээлэх боломжгүй гэсэн байна.

ҮСХ-ноос 2017 оны 10 сард тогтвортой хөгжлийн зорилгын нийт 244 шалгуур үзүүлэлтийг хамруулсан үнэлгээг дахин хийсэн байна. Эндээс харахад Монгол Улсад хамааралгүй 11, хамааралтай 233 байгаа бөгөөд үүнээс гарах боломжтой 113, гарах боломжгүй 120 шалгуур үзүүлэлт байна гэж үзжээ. Өөрөөр хэлбэл хэмжих боломжийн хувьд нийт шалгуур үзүүлэлтийн тал гаруй хувь нь Монгол Улсын хувьд гарах боломжгүй гэж үзсэн байна. Гарах боломжтой үзүүлэлтийн хувьд зарим тооцооллыг ҮСХ 2016, 2017 онд хийсэн байжээ (Хавсралт 5.3).

Харин “ТХҮБ 2030” -ын хувьд үр дүнг илэрхийлэх үндсэн 20 үзүүлэлтийн суурь болон зорилтот түвшинг тодорхойлж өгсөн байна. ҮСХ тус үндсэн 20 үзүүлэлтээс гарах боломжтой үзүүлэлтүүдийг 2015, 2016, 2017 оны байдлаар тооцсон байна (Хавсралт 5.4). “Алсын хараа-2050” бодлогын баримт бичиг батлагдсанаар “ТХҮБ 2030” хүчингүй болсон тул НХБ-ын баримт бичгийн уялдааг энэхүү судалгаанд тусгаагүй болно.

Шалгуур үзүүлэлтийг үнэлэх байгууллага

Шалгуур үзүүлэлтүүдийн хувьд ҮСХ нь тогтвортой хөгжлийн зорилгын, БОАЖЯ нь ногоон хөгжлийн бодлогын шалгуур үзүүлэлтүүдийн биелэлтийг тооцож, үнэлэх ажлыг хариуцан ажиллаж байна.

Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу тайлан гарч байна. Тодруулбал, МУЗГ-ын 2017 оны 89-р тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу ногоон хөгжлийн бодлогын хэрэгжилтийн явцын үнэлгээг жил болгон хийж байна.

1.2. Үнэлгээний арга зүй, хамрах хүрээ

Энэхүү үнэлгээг НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрөөс боловсруулсан бодлогын үнэлгээний аргачлалын дагуу гүйцэтгэв. Судалгааны аргачлалын хувьд 1) бодлогын баримт бичгүүд, түүний биелэлтийн тайлан болон бусад тоон мэдээллийг үнэлэв (Хавсралт 5.2) 2) бэлдсэн асуултуудын дагуу уулзалт, ярилцлагууд зохион байгуулсан, 3) мөн тусгайлсан хэлэлцүүлэг хийсэн болно.

НХБ болон бусад баримт бичгүүд засгийн газрын ногоон эдийн засгийг хөгжүүлэх үйл ажиллагааны үндсэн суурь болж байна.

Ногоон хөгжлийн бодлогын зорилго, зорилт, үйл ажиллагаа, шалгуур үзүүлэлтүүд нь “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлого болон ТХЗ-д хэрхэн тусгагдсаныг бид нийцлийн хувь хэмээх үзүүлэлтээр илэрхийлсэн болно. Нийцлийн хувийг “хангалттай сайн”, “хангалттай”, “хангалттай бус”, “хангалтгүй” (агуулгын хувьд тусгагдсан боловч үнэлгээ хийхэд хангалтгүй), мөн “огт тусгаадаагүй” гэж ангилсан. Нийцлийн хувийг гаргахдаа тухайн заалтад орсон агуулга бүр нөгөө харьцуулж байгаа бодлогын холбогдох заалтад яаж тусгагдсан хэрхэн томъёологдсон байгааг нь харгалзан үзсэн. Түүнчлэн “ТХҮБ 2030” болон Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого зэрэг бодлогуудын агуулгыг харсан болно. Энэхүү тайланд нийцлийн хувь өндөртэй буюу хангалттай сайн, хангалттай тусгагдсан зорилт, үйл ажиллагааг бус төдийлөн хангалттай бус, хангалтгүй болон огт тусгаадаагүй заалтуудыг дэлгэрүүлэн тайлбарлаж оруулахыг хичээсэн болно.

Ногоон хөгжлийн бодлогын хэрэгжилтийг үнэлэхдээ дараах тоон мэдээллийг ашиглав. Үүнд: 1) ҮСХ-ноос гаргадаг “Тогтвортой хөгжлийн зорилтуудын шалгуур үзүүлэлтүүдийн тоон мэдээлэл” 2) ҮСХ-ны Статистикийн мэдээллийн нэгдсэн сан (2021) 3) БОАЖЯ-ын байгаль орчны мэдээллийн сан (2021).

2019 оны 10-р сараас 12-р сарын хүртэл хугацаанд нийт 18 хүнтэй биелчлэн ярилцлага хийсэн (Хэлэлцүүлгийн



хөтөлбөр болон ярилцлага хийсэн хүмүүсийн жагсаалтыг Хавсралт 5.1-д оруулав.)

Ярилцлагад хамрагдсан хүмүүсийг мэдлэг, чадвар болон бодлогын хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагаанд хамрагдсан байдлаар дараах гурван өөр бүлгээс түүвэрлэн сонгосон: 1) бодлого боловсруулах үйл явцад оролцсон эсвэл бодлого хэрэгжүүлэх үүрэгтэй төрийн албан хаагчид 2) уулзалт, хэлэлцүүлэгт оролцсон иргэний нийгэм, эрдэм шинжилгээний байгууллагын төлөөлөл 3) бизнесийн холбоо болон тэдгээрийн төлөөлөл.

Ярилцлагыг хийхдээ дараах ерөнхий асуултуудыг урьдчилан бэлтгэсэн болно.

1. Ногоон хөгжлийн бодлого батлагдан хэрэгжсэнээс хойш ямар өөрчлөлт, эерэг үр дүн (хэрэв гарсан гэж үзэж байвал) гарсан бэ?
2. Таны ажиллаж буй салбарын ногоон шилжилтийн явц хэр байна вэ?
3. Та НХБ-ын хэрэгжилтийн явцыг хэрхэн үнэлэх вэ?
4. НХБ-ын зорилго, зорилтуудад хүрч, биелэх боломжтой юу?
5. Цаашид юу хийх шаардлагатай гэж бодож байна вэ?

НХБ-ын тойм, НХБ-ын дунд хугацааны хэрэгжилтийн үнэлгээ болон Т21 загварын үр дүнг танилцуулах зорилгоор 2019 оны 12-р сарын 4-нд оролцогч талуудын хамруулсан хэлэлцүүлэг зохион байгуулсан.

Энэхүү арга хэмжээнд засгийн газрын төлөөлөл, олон улсын хамтын ажиллагааны түншүүд, бизнес эрхлэгчид болон иргэний нийгэм, эрдэмтэн судлаачид зэрэг нийт 102 хүн оролцов.

НХБ-ын хэрэгжилтийн явцыг үнэлэхэд мэдээллийн эх сурвалжийг өнөөгийн нөхцөлд хэрхэн тодорхойлох нь тодорхойгүй байсан нь арга зүйн бэрхшээл болж байв. Түүнчлэн, бодлогын хэрэгжилтийн явцыг үнэлэхэд аль байгууллагын боловсруулсан ямар үзүүлэлтүүдийг ашиглах нь зүйтэй талаар мэдээлэл хомс байв.

Үүнтэй холбогдуулан тайлангийн 2-р хэсэгт багтсан НХБ-ын зарим зорилт, шалгуур үзүүлэлтүүдийн бодит гүйцэтгэлийг баталгаажуулахын тулд хэд хэдэн эх сурвалжийн гүйцэтгэлийн тайланг харьцуулсан болно. 14 шалгуур үзүүлэлт тус бүрээр 2013 оны тоо мэдээг бодлогын баримт бичигт тусгаагүй нь дараах шалтгаантай⁶. Үүнд: 1) Зарим шалгуур үзүүлэлт (тухайлбал барилгын дулаан алдагдал, ногоон хөгжилд зарцуулсан дотоодын нийт бүтээгдэхүүний хувь, засгийн газрын ногоон худалдан авалтын эзлэх хувь гэх мэт) нь өмнө нь хэмжигдэж байгаагүй шинэ, 2) Зарим шалгуур үзүүлэлтийг хэд хэдэн байгууллага гаргах боловч тоо мэдээ нь хоорондоо зөрөх, 3) Зарим шалгуур үзүүлэлт нь (тухайлбал байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх хувь, ХАА, боловсруулах үйлдвэрлэлийн ДНБ-д эзлэх хувь) 2013 онд хэд байсан, ямар байгууллага энэ тоог гаргаж өгөх, хэрхэн тооцох арга зүй нь тодорхойгүй зэрэг багтана.

⁶ ХААИС-ийн ЭЗБС-ийн сургалтын хөтөлбөрийн эрхлэгч Доктор Г.Ганзоригтой хийсэн ярилцлага.



2. Бодлогын Хэрэгжилтийн Үнэлгээ

2.1. Бодлого боловсруулах үйл явц

2012 онд МУЗГ Байгаль орчин, ногоон хөгжлийн яамыг байгуулснаар НХБ боловсруулах эхлэл тавигдсан.

Бодлого боловсруулах үйл явцын өмнөх жилүүдэд тодорхой тооны үйл явдлууд тохиолдсон. Тодруулбал, 2009-2010 онд Монгол Улсад нүүрлэсэн зудаар 8.8 сая толгой мал хорогдож ойролцоогоор 264 тэрбум төгрөг (192 сая доллар) буюу 2009 оны байдлаар Монгол Улсын ДНБ -ий 4.4 хувьтай тэнцэх хэмжээний хохирол

учирсан (2011 Бенсон). Хэдийгээр зуд нь Монгол Улсад цоо шинэ үзэгдэл биш боловч уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй хоёр жил дараалан үргэлжилсэн 2009-2010 оны зудын гамшиг өмнөх жилүүдээс илүү ширүүн нүүрлэж, малчдын амьжиргаа, улс орны эдийн засагт ихээхэн хүндрэл учруулсан. Үүний хариуд Монгол Улс байгаль орчны тэнцвэртэй байдлыг хангах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон нийгэм эдийн засгийн салбарыг хөгжүүлэх, эмзэг байдал, эрсдлийг бууруулах, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, эдийн засгийн үр ашиг, үр ашгийг дээшлүүлэх, түүнчлэн “Ногоон хөгжил” бодлогыг хэрэгжүүлэх (УИХ 2011) зорилгоор 2011-2021 он хүртэл хоёр үе шаттай хэрэгжих Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр (УАӨҮХ)-ийг боловсруулсан. Энэхүү хөтөлбөрөөс гадна НХБ-ыг боловсруулж, хэрэгжүүлэхэд нөлөөлсөн үндэсний болон олон улсын түвшинд болсон чухал үйл явдал, арга хэмжээг 2-р хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 2. Бодлого боловсруулах үйл явцын он цагийн товчоо

Олон улсын хэмжээнд	Үндэсний хэмжээнд
2012	
2012 онд Бразил улсад чуулсан “Рио +20” тогтвортой хөгжлийн олон улсын дээд хэмжээний чуулга уулзалтаас баталсан “Бидний хүсч буй ирээдүй” тунхаглалд ногоон эдийн засгийг тогтвортой хөгжилд хүрч, ядуурлыг арилгах хэрэгсэл гэж хүлээн зөвшөөрсөн. Монгол Улсыг төлөөлж чуулга уулзалтад оролцсон улс төрчид, хүрээлэн буй орчны идэвхтнүүд болон шинжээчдээс бүрдсэн төлөөлөгчид чуулга уулзалтын дараа Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг боловсруулах ажлыг эхлэв. Тэдний эхэндээ ногоон хөгжлийг ядууралтай тэмцэх хөшүүрэг болгон ашиглахыг зорьж байв.	Жил бүрийн хоёрдугаар сард болдог “Монголын эдийн засгийн чуулган” -ы үеэр “Ногоон соёл иргэншил” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулав. Хэлэлцүүлгийн үеэр “Монголын уламжлалт нүүдэлчин соёл иргэншил” -ийн мэргэн ухааныг орчин үеийн байгаль орчинд ээлтэй (нүүрстөрөгч багатай) эдийн засгийн хөгжилтэй хослуулах боломжит шинэ загварыг танилцуулсан. Уг чуулган нь тухайн үед улс төрчид, иргэний нийгмийн төлөөлөл, бизнесийн удирдагчдын дунд санал бодлоо солилцдог нөлөө бүхий платформ байв. Монголын онцлогтой “Уламжлалт боловч орчин үеийн” тогтвортой хөгжлийн санааг оролцогчид таатай хүлээж авсан. Үүний үр дүнд чуулганд оролцогчдын дийлэнх нь ногоон соёл иргэншлийн үзэл баримтлалыг төрийн бодлого болгох ёстой гэдэг дээр санал нэгджээ.

Хүснэгт 2. Бодлого боловсруулах үйл явцын он цагийн товчоо

Олон улсын хэмжээнд	Үндэсний хэмжээнд
2012	
	- УИХ-ын сонгуулиар олонхын суудал авч ялалт байгуулсан нам байгаагүй тул долдугаар сард хамтарсан засгийн газар байгуулснаар Иргэний зориг-Ногоон намаас БОНХЯ-ны сайд томилогдов. Ингэснээр ногоон бодлогын төсөл боловсруулах яам хоорондын ажлын хэсгийг байгуулсан. - БОНХЯ-аас ногоон хөгжилтэй холбоотой олон талын оролцогчдыг хамарсан форум, семинарыг удаа дараа зохион байгуулсан. Бодлогын баримт бичгийн нэрийн анхны санал "Ногоон эдийн засгийн бодлого" эсвэл "Ногоон соёл иргэншлийн үзэл баримтлал" байв. Эдгээр арга хэмжээний үеэр бодлогыг хэрэгжүүлэх байгууллагын талаар хэлэлцсэн. Нэг хэсэг нь уялдаа холбоог жигд болгох үүднээс янз бүрийн төлөөллөөс бүрдсэн үндэсний зөвлөлийг санал болгож байсан бол зарим хэсэг нь агентлагуудыг удирдах эрх мэдэлтэй Ерөнхий сайдын ажлын албыг дэмжиж байв. Харин үлдсэн хэсэг нь энэ бодлогыг БОНХЯ хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэж байв. - Үүний зэрэгцээ тухайн үед бодлого боловсруулагчид болон олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл тогтвортой хөгжил, байгаль орчны асуудлаар ихээхэн анхаарал хандуулж байв.
2013	
Монгол Улс НҮБ-ын НЭЗТТ-д нэгдэж, дэмжлэг авсан анхны орнуудын нэг болов.	БОНХЯ-наас Дэлхийн байгаль орчны өдрийг тохиолдуулан "Үндэсний ногоон хөгжлийн форум" -ыг зохион байгуулав. Үүний дараагаар БОНХЯ-наас "Ногоон соёл иргэншлийн үндэсний үзэл баримтлал" -ын төслийг боловсруулсан.
2014	
	НХБ-ыг УИХ соёрхон батлав.
2015	
- Нью-Йорк хотноо болсон НҮБ -ын Тогтвортой хөгжлийн дээд хэмжээний уулзалтын үеэр 17 үндсэн зорилт бүхий "Тогтвортой хөгжлийн зорилт 2030" -ыг баталсан. - НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенцын /УАӨСК/-ийн талуудын XXI бага хурал /COP 21/-аар Парисын хэлэлцээрийг хэлэлцэж дэлхийн цаг уурын өөрчлөлт, хамтын үйл ажиллагаа, хүчин чармайлтад анхаарлаа хандуулав	- Монгол Улс 2015 оны Парисын хэлэлцээрийн өмнө УАӨҮХ болон Үндэсний тодорхойлсон хувь нэмрийг (ҮТХН) тодорхойлж, НҮБ -ын УАӨСК-д хүргүүлсэн. Монгол Улсын ҮТХН-ийн баримт бичгийг Даян дэлхийн байгаль орчны сангийн санхүүжилтээр НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр болон Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (ГООУХАН)-ийн дэлхийн улс орнуудын зорилтот хувь нэмрийг дэмжих хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр тухайн үеийн Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яамны дэргэдэх Байгаль хамгаалах сангийн Уур амьсгалын өөрчлөлтийн төсөл хэрэгжүүлэх нэгжээс боловсруулсан.. - Монголын банкны холбоо хоёр дахь удаагийн Тогтвортой санхүүжилтийн форумыг зохион байгуулав.
2016	
Парисын гэрээ хүчин төгөлдөр болсон бөгөөд 2020 оны 2-р сарын байдлаар УАӨСК-ийн бүх гишүүн орнууд гэрээнд нэгдэн орсон.	- УИХ "ТХҮБ 2030" -ийг батлав. - Монголын банкны холбоо гурав дахь удаагийн Тогтвортой санхүүжилтийн форумыг зохион байгуулав.

Засгийн газрын зүгээс бодлогын баримт бичгийн төслийг 2013 онд УИХ-д соёрхон батлуулахаар хүргүүлсэн. Тухайн үед бодлого нь ерөнхий үзэл баримтлал, зорилго, үндсэн зарчмуудыг тодорхойлсон “Ногоон соёл иргэншлийн үндэсний үзэл баримтлал” болон ойрын жилүүдэд улс орны үзэл баримтлалыг хэрхэн хэрэгжүүлэхийг тусгасан “Дунд хугацааны стратеги” гэх хоёр өөр баримт бичгээс бүрдэж байв.

БОНХЯ-ын боловсруулсан “Ногоон соёл иргэншлийн үндэсний үзэл баримтлал” бодлогын баримт бичгийн анхны төсөл байгаль орчны хамгаалал, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэх тэгш бус байдал, өлсгөлөн зэрэг сөрөг үр дагаврын эсрэг авах арга хэмжээ гэх мэт илүү өргөн хүрээг хамарч байсан боловч засгийн газрын хуралдааны үеэр эдийн засагтай холбоотой зарим заалтыг холбогдох яамны чиг үүрэг гэж үзсэн тул баримт бичгийн төслөөс хассан байна.

УИХ-ын хэлэлцүүлгийн үеэр ажлын хэсэг байгуулагдаж, баримт бичгийн төсөлтэй танилцаж холбогдох нэмэлт өөрчлөлт оруулах ажлыг эхлүүлсэн. Судалгааны явцад хийгдсэн уулзалт, ярилцлагын үр дүнгээс харахад УИХ-ын ажлын хэсэг дорвитой өөрчлөлт хийгээгүй ч хоёр бодлогын баримт бичгийг нэгтгэн 2020, 2030 онуудад хүрэх зорилт болон шалгуур үзүүлэлтүүдийг тусгай бүлэг болгон “Ногоон хөгжлийн бодлого” гэсэн албан ёсны нэршилтэй болжээ.

2016 оны УИХ-ын сонгуулиар байгуулагдсан засгийн газар нь яамны нэрээс “ногоон хөгжил” гэсэн томъёоллыг хасаж БОАЖЯ болсон хэдий ч Ногоон хөгжлийн бодлогыг хариуцсан газар үйл ажиллагаагаа үргэлжлүүлсэн хэвээр байна.

БОНХЯ-ны зүгээс Ногоон хөгжлийн бодлогын ажлыг өөрсдөө голлон боловсруулсан гэж ярилцлагад оролцсон хүмүүс тэмдэглэжээ. Гэсэн хэдий ч цаг хугацаа, тухайн үеийн нөхцөл байдлаас хамаарч бодлого боловсруулах явцад хувийн хэвшил болон бусад оролцогч талуудын оролцоо нь харьцангуй бага байсан гэж дурджээ. Энэ нь хувийн хэвшлийн төлөөлөл бодлогын ерөнхий зорилго эсвэл салбарын өргөн хүрээний асуудалд анхаарал хандуулахын оронд дан ганц өөрсдийн хүндрэл, бэрхшээлийг шийдвэрлүүлэх эрмэлзэлтэй байдагтай холбоотой юм.

НХБ батлагдсаны дараагаар МУЗГ тус бодлогын хэрэгжилтийг хангах зорилгоор “Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-г баталсан. Тус төлөвлөгөөг гаргахад аль болох олон

талын оролцоог хангаж, ажлын хэсгүүд байгуулсан ч хувийн хэвшлийн оролцоо сул байв. Гэхдээ судлаачдын үзэж буйгаар хувийн хэвшлийн саналыг бодлого боловсруулах явцад судлагдсан баримт бичиг болон уулзалт, хэлэлцүүлгүүдийн мэдээллээс бодлого боловсруулагчдын зүгээс оруулсан байж болно гэж үзсэн.

Ярилцлагын зарим оролцогчид тус бодлогыг хэрэгжүүлэх хугацааг хэтэрхий давчуу буюу хэт өөдрөгөөр төсөөлсөн бөгөөд 2020 оны зорилтот түвшин биелэх боломжгүй гэж үзжээ. Үүний зэрэгцээ, үйл ажиллагааны төлөвлөгөө нь үндсэн чиг үүрэгтээ их ачаалал авдаг төрийн албан хаагчдын хувьд хүндрэл учруулж болзошгүй юм. Түүнчлэн, НХБ нь Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль батлагдахаас өмнө гарсан тул зөрүү гарч болзошгүйг зөвлөлдөх уулзалтын үеэр оролцогчид онцолж байв.

2.2. Бодлогын хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа

НХБ-ыг хэрэгжүүлэхэд хэрэг болохуйц хэд хэдэн үйл ажиллагаа хийгдсэн. Тухайлбал Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгийг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үе шат, баримтлах зарчим, оролцогч талуудын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох, хөгжлийн бодлого төлөвлөлтийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх зорилгоор Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийг 2015 оны 11-р сард баталсан (2020 онд шинэчлэгдэн найруулсан). Монгол Улс нь далайд гарцгүй, аж үйлдвэржилт сул хөгжсөн, хүн амын багагүй хувь нь хөдөө, дэд бүтэц султай суурин газар мөн гэр хороололд амьдардаг зэрэг онцлогийг харгалзан үзвэл энэхүү хууль болон хөгжлийн бодлогын бусад холбогдох төлөвлөгөө, схем нь нэн шаардлагатай юм. Ногоон хөгжлийн бодлогын үйл ажиллагааны төлөвлөгөө батлагдсаны дараагаар ҮСХ-ны даргын А/130 тушаалаар “Ногоон хөгжлийн үндсэн үзүүлэлтүүд түүнийг тооцох аргачлалын журам”-ыг БОАЖЯ-ын саналыг тусгаж баталсан байна.⁷ ҮСХ зүгээс зургаан шалгуур үзүүлэлтээс бусдыг нь үнэлэх боломжтой гэж үзсэн. Ногоон хөгжлийн шалгуур үзүүлэлтүүдийг дан ганц ҮСХ үнэлж байгаа нь салбар дундын асуудлуудыг орхигдуулах зэрэг хүндрэл гарч болзошгүй юм.

Цаашдын үйл ажиллагаанд 13 аймгийн ногоон хөгжлийн зорилтуудыг тодорхойлох, ногоон зээлийн

⁷ ҮСХ-той хийсэн ярилцлага болон БОАЖЯ-ны зүгээс хэлэлцүүлгийн үеэр дурдаж байв.

сан байгуулах болон байгаль орчинд ээлтэй, дэвшилт арга, технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хөнгөлөлттэй нөхцөлтэй банкны зээл олгох зэрэг байдлаар урамшуулах багтсан. Гэсэн хэдий ч, эдгээрийг хэрэгжүүлэх стандартуудыг нь тодорхой болгож батлаагүйн улмаас зарим ажлын хэрэгжилт хойшилсон байна.

НХБ-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хэд хэдэн салбарын бодлогын баримт бичиг, холбогдох журмууд гарсан байна. Үүнд “Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөр”, “Ногоон боловсролын хөтөлбөр” зэрэг багтана. Цаашилбал Хог хаягдлын хуулийн хүрээнд МУЗГ-аас журам боловсруулж (2018 оны 189-р тогтоол) нэг удаагийн нийлэг уутыг хориглох шийдвэр хэрэгжиж байна. МУЗГ-ын тусгай сангийн хуульд өөрчлөлт оруулах замаар “Байгаль орчны сан”-г “Байгаль орчин, уур амьсгалын сан” болгон өргөжүүлсэн. Уулзалт, хэлэлцүүлгийн үеэр НХБ нь эдгээр хууль тогтоомж, үйл ажиллагааг хэрэгжүүлэх таатай нөхцлийг бүрдүүлсэн талаар оролцогчид онцолж байв.

Мэдээллийг ил тод болгох хүрээнд дараах онлайн архив, цахим сан, веб хуудас хийгдсэн. Үүнд:

- Ногоон барилгын чиглэлээр: www.greenbuilding.mn
- Байгаль орчны мэдээллийн сан: www.eic.mn
- Тогтвортой хөгжлийн боловсролд: www.nogoon.mn
- Статистик шалгуур үзүүлэлтүүд: www.1212.mn
- Ойн судалгаа: www.forest-atlas.mn⁸

2.3. НҮБ -ын тогтвортой хөгжлийн зорилтууд болон үндэсний бодлогын баримт бичгийн уялдаа

Бодлогын уялдааны хувьд ногоон хөгжлийн бодлогын зорилтууд нь Монгол Улсын бусад бодлоготой уялдаж чадаж байна. Тухайлбал, “ТХҮБ 2030” (2020 онд хүчингүй болсон), Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого (УИХ-ын 2014 оны 18 дугаар тогтоол), МУЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр (УИХ-ын 2016 оны 45 дугаар тогтоол), Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого (УИХ-ын 2015 оны 62 дугаар тогтоол), Монгол Улсын ерөнхийлөгчийн 2015 оны 77 дугаар зарлиг, МУЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрийг

хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (МУЗГ-ын 2016 оны 121 дүгээр тогтоол), Гурван тулгуурт хөгжлийн бодлого (МУЗГ-ын 2018 оны 42 дугаар тогтоол) зэрэг болно.

Дараах хоёр хэсэгт НХБ нь “Алсын хараа-2050” болон ТХЗ-тай хэрхэн уялдаж байгаа талаар авч судалсан үр дүн оруулав.⁹

2.3.1. Алсын хараа - 2050

НХБ-ын зорилго, стратегийн зорилтуудыг “Алсын хараа – 2050” урт хугацааны бодлогын баримт бичигтэй, НХБ-ын хэрэгжилт, үйл ажиллагааг “Алсын хараа-2050”-ын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөтэй харьцуулав. 1.2-т дурдсанчлан нийцлийн хувь өндөртэй буюу хангалттай сайн, хангалттай тусгагдсан зорилт, үйл ажиллагааг бус төдийлөн хангалттай бус, хангалтгүй болон огт тусгагдаагүй заалтуудыг түлхүү анхаарав.

Зорилго

УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” урт хугацааны бодлогын баримт бичигт Дэлхий нийтийн хөгжлийн үзэл баримтлалын дагуу Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлогын суурь эхлэлтийн цэг нь ногоон хөгжил байх бөгөөд байгаль орчны нөөц бололцоо, газар зүйн байршлын давуу тал дээрээ үндэслэн эдийн засаг, дэд бүтэц, бүс нутгийг хөгжүүлэх болно хэмээн ногоон хөгжлийг тодорхойлжээ. Эндээс харахад “Алсын хараа-2050” бодлогын баримт бичиг нь ногоон хөгжлийн бодлогын үзэл баримтлалын ерөнхий агуулгыг багтаасан гэж дүгнэхээр байна.

Стратегийн зорилтууд

НХБ нь 6 стратегийн зорилттой бөгөөд тэдгээрийг “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын 9 зорилттой харьцуулсан. Тус бодлогын зургадугаар бүлэгт ногоон хөгжлийн үзэл баримтлалыг даган хэрэгжүүлэхээр тусдаа зорилт дэвшүүлсэн бөгөөд энэ нь ногоон хөгжлийн бодлогын зорилтуудыг багтаасан томоохон зорилт байна. Холбогдох дүн шинжилгээнд дурдсанчлан эдгээр бодлогын баримт бичгийн зорилтуудын ерөнхий нийцэл нь “хангалттай” байна. Өөрөөр хэлбэл ногоон хөгжлийн бодлогын 6

⁸ Дээр дурдсан төсөл, хөтөлбөрийн хэрэгжих хугацаа дууссан тул зарим цахим хуудас одоогоор ажиллахгүй байна. ЭЗБӨЧСТ-ийн зүгээс ногоон эдийн засгийн мэдлэг, мэдээллийг түгээн таниулах зорилгоор www.nogoonhutuch.mn цахим хуудсыг бүтээн ажиллуулж эхэлсэн.

⁹ Эдгээр бодлогын хоорондын нийцлийг “Ногоон хөгжлийн бодлогыг “Алсын хараа-2050”, “Тогтвортой хөгжлийн зорилтууд”-тай харьцуулсан үр дүн” хэмээх тусдаа баримт бичигт оруулав.

зорилтын дийлэнх нь “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогод тусгагдсан байна. Ногоон хөгжлийн бодлогын хоёр, тав, зургадугаар стратегийн зорилтууд “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогод “хангалттай сайн” тусгагдсан байна. Харин нэг болон дөрөвдүгээр зорилтууд “хангалттай” тусгагдсан байна.

Ногоон хөгжлийн бодлогын гуравдугаар стратегийн зорилтын “Ногоон эдийн засгийг дэмжих санхүүжилт, татвар, зээл, урамшууллын оновчтой хөшүүргийг нэвтрүүлж, байгаль хамгаалал, хүний хөгжил, цэвэр технологийг дэмжих хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ” санхүүжилт, татвар, зээл, урамшууллын хөшүүрэг нэвтрүүлэх асуудал “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогод “хангалттай бус” тусгагдсан байна.

НХБ-ын нэгдүгээр стратегийн зорилтод “Байгалийн нөөцийн хэмнэлттэй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай үйлдвэрлэл, хэрэглээг хөгжүүлнэ” гэсэн бол “Алсын хараа-2050”-ын зургадугаар зорилтын дөрөв дэх хэсэгт “Нүүрстөрөгч багатай, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон эдийн засгийг хөгжүүлж, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах олон улсын хүчин чармайлтад хувь нэмэр оруулна” хэмээн тусгасан ч хэрэгжүүлэх арга замын хувьд тодорхойгүй байна. Өөрөөр хэлбэл хэрэв дэлхий нийтийг хамарсан санаачилга гарахгүй бол Монгол Улс өөрийн санаачилгаар ногоон эдийн засагт шилжих, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах ажилд анхаарал хандуулахгүй мэт харагдаж байна. Гэхдээ эдгээр зорилтууд хоорондоо уялдаатай учир “Алсын хараа-2050”-ын зорилтууд хангагдаж чадвал НХБ-ын зорилтуудын ерөнхий биелэлтэд нөлөөлөх боломжтой. Иймд хоорондын нийцлийг “хангалттай” гэж үзэж байна.

“Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын гурав болон дөрөвдүгээр зорилгод хөдөлмөр эрхлэлтийг тогтвортой нэмэгдүүлж дундаж давхарга зонхилсон, ядуурал эрс буурсан эдийн засаг, нийгмийг хөгжүүлэхээр тусгасан нь НХБ-ын стратегийн дөрөвдүгээр зорилттой хангалттай нийцэж байв. Гэсэн хэдий ч “ногоон ажлын байр” гэсэн тодорхойлолт “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогод төдийлөн сайн тусгагдаагүй байна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

НХБ-ын стратегийн 6 зорилтын хүрээнд нийт 52 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр заасан бол “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын 9 зорилгын хүрээнд 958 үйл ажиллагааг 2021-2050 онд

хэрэгжүүлэхээр баталсан байна. Үүнээс ногоон хөгжил буюу зургадугаар бүлгийн хүрээнд 64 үйл ажиллагаа буюу нийт үйл ажиллагааны 7 хувьд ноогдож байв. “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын бусад бүлгүүдэд ногоон хөгжлийг дэмжих, үзэл баримтлалыг дагах зэрэг цөөн хэдэн үйл ажиллагаа төлөвлөгдсөн ч нийт үйл ажиллагааны 10 хувьд хүрэхгүй байна.

НХБ-ын хэрэгжүүлэх нийт 52 үйл ажиллагааны 35 нь “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогод хангалттай сайн, 8 нь хангалттай, 5 нь хангалттай бус, 3 нь хангалтгүй, нэг нь огт тусгагдаагүй байна

Хоёр бодлогын баримт бичгийн ерөнхий нийцлийг хангалттай гэж дүгнэж байна. Өөрөөр хэлбэл “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогыг 2030 он дуустал амжилттай хэрэгжүүлэхэд ногоон хөгжлийн бодлогын хэрэгжилтийн дийлэнх хувь хангагдах боломжтой юм. НХБ-ын үйл ажиллагаа “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын 2012-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаанд тусгагдсан байдлыг зорилт тус бүрээр нь авч үзвэл 1, 2, 4, 5, 6 зорилтууд ерөнхийдөө хангалттай тусгагдсан бол 2 дугаар зорилт хангалттай бус тусгагдсан байна.¹⁰

НХБ-ын нэгдүгээр зорилтын үйл ажиллагаанаас “2030 онд эрчим хүчний салбарын хүлэмжийн хийн ялгаруулалтыг 20 хувиар бууруулж, эрчим хүчний хэт их хэрэглээг багасгах, дамжуулалтын алдагдлыг бууруулах, үнийн бодлогыг оновчтой болгох замаар нийт эрчим хүчний үйлдвэрлэлд ашигладаг сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг 2020 онд 20 хувь, 2030 онд 30 хувиар тус тус нэмэгдүүлэхээс гадна уламжлалт болон уламжлалт бус газрын тосны эх үүсвэрийн хайгуул, олборлолтод олон улсын стандартыг нутагшуулж мөрдөх, байнгын хяналт-шинжилгээ хийх замаар орчны бохирдлоос сэргийлэх” гэдэг үйл ажиллагаа нь “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогод төдийлөн хангалттай тусгагдаагүй байна.

Уг урт хугацааны бодлогод ногоон барилга барихад сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг ашиглах талаар хэрэгжүүлэхээр тусгасан ч энэ чиглэлийн үйл ажиллагааг дэмжих, урамшуулах хөшүүрэг механизмыг бий болгох тухай заалт ороогүй байна. НХБ-д тэдгээрийн хүрэх түвшинг маш тодорхой заасан бол “Алсын хараа-2050”-д ерөнхий байдлаар тусгагдсан байв. Мөн газрын тосны үйлдвэр байгуулахаар төлөвлөсөн ч НХБ-д заасны

¹⁰ Судлаачдын зүгээс зорилт тус бүрээр хийсэн харьцуулалт

дагуу байгаль орчинд нөлөөлөх байдлыг олон улсын стандартын дагуу тодорхойлж бохирдол, хохирлоос урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа хэрэгжүүлэх тухай огт дурдаагүй байна. Эдгээр нь энэхүү 2 бодлогын нийцлийн хувийг бууруулах гол шалтгаан болж байна.

Бидний харьцуулалт хийж байгаа НХБ-ын хоёрдугаар зорилтын хүрээний үйл ажиллагаануудаас 3.2.2¹¹, 3.2.6¹² болон 3.2.8¹³ дахь үйл ажиллагаанууд нь “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогод хангалтгүй нийцэж байна. Тухайлбал “Алсын хараа-2050”-н хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 4.2.14 дахь заалтад хүнд үйлдвэрүүдийг шинээр нэмж байгуулахаар тусгасан нь ногоон хөгжлийн зарчмыг баримтлахгүй бол ногоон хөгжлийн бодлогын 3.2.2 дахь заалттай зөрчилдөнө гэж үзэж байна. Учир нь хүнд үйлдвэрүүд нь байгалийн нөөцийг ихээр ашигладаг, хаягдал бохирдол ихээр үүсгэдэг тул тэдгээрийг шийдэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх тухай төлөвлөгөө дутмаг байв.

Гэхдээ хүнд үйлдвэрийг шинээр барих газар нь байгалийн нөөц газар, дурсгалт газар, паркийн газрын хилтэй давхцуулахгүй байх заалт оруулж, байгаль орчны стратегийн үнэлгээ (БОСҮ)¹⁴ хийсэн тохиолдолд энэхүү 2 бодлогын холбогдох заалтууд хоорондоо харшлахгүй байх боломжтой юм. Тиймээс урьдчилан сэргийлэх зохицуулалтын арга хэмжээг сайтар хэрэгжүүлэх нь зүйтэй байна.

НХБ-ын 3.2.6 дахь заалт буюу генийн өөрчлөлттэй организмтой холбоотой хэрэгжүүлэх үйл ажиллагаа байна. НХБ-д “Хувиргасан амьд организмын хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд үзүүлэх эрсдэлийг үнэлж, урьдчилан сэргийлэх чадавхыг бэхжүүлж, импорт, худалдааны хязгаарлалт тогтоох” гэсэн тодорхой заалт байхад “Алсын хараа-2050”-ын 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд огт

тусгагдаагүй байна. Уг үйл ажиллагааны төлөвлөгөөнд хүнсний аюулгүй байдлыг сайжруулна, импортын барааг хянаж шалгах лабораторийн хүчин чадлыг сайжруулна гэх ерөнхий заалтууд байна. Эдгээрт нь генийн өөрчлөлттэй организм багтаж байгаа эсэх, түүнийг хил нэвтрүүлэх, ашиглах талаар Монгол Улс ямар бодлого баримтлах нь тодорхойгүй байна. Сүүлийн жилүүдэд бусад улс орнууд генийн өөрчлөлттэй бүтээгдэхүүн хэрэглэхээс татгалзаж байхад бид одоо хүртэл ямар нэгэн шийдвэр гаргаагүй төдийгүй урт хугацааны бодлогын баримт бичигт тодорхой заалт оруулаагүй байна.

Түүнчлэн НХБ-ын 3.2.8 дахь заалтад нутгийн иргэдийн оролцоонд түшиглэсэн байгалийн нөөцийн ашиглалтын менежментийг хэрэгжүүлэхээр тусгасан ч “Алсын хараа-2050”-д иймэрхүү төрлийн үйл ажиллагаа тусгагдаагүй байна. “Алсын хараа-2050”-д нөхөрлөлийг зах зээлтэй холбох, кластерээр хөгжүүлэх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх гэдэг үйл ажиллагаа төлөвлөсөн нь нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн нөөц менежментийг хөгжүүлэх чадамжгүй гэж үзэж байгаа тул нийцлийн хувь хангалтгүй байна.

НХБ-ын 3.3.8-д заасан “Ногоон хөгжлийн үзүүлэлтийг үндэсний тооцооны системд тусган байгаль орчноос нийгэм, эдийн засгийн хөгжилд оруулах хувь нэмрийг тооцох” хэмээх үйл ажиллагаа “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогод огт тусгагдаагүй байна. Үндэсний тооцооны систем буюу статистикийн мэдээнд ногоон хөгжлийн үзүүлэлтийг тусгаагүй байгаа нь ногоон хөгжлийн үйл явцыг тодорхойлох боломжгүй болгож байна гэж үзэхээр байна. Эндээс харахад аливаа хэрэгжүүлсэн байгаль орчинд ээлтэй, ногоон үйл ажиллагааг улсын статистикийн мэдээллээр баталгаажуулахгүй орхих, үйл ажиллагааг бүрэн ашиглаж чадахгүй түвшинд хүрэх эрсдэл байгааг харуулж байна. Үүнийг “Алсын хараа-2050”-ын 2031 оноос эхлэн хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах, боломжтой бол түүнээс өмнө гарсан бусад бодлогын баримт бичигт тусгах шаардлагатай. НХБ-ын давуу талуудын нэг нь ҮСХ-оос хэрэгжүүлж буй ногоон хөгжлийн үзүүлэлтийг үндэсний тооцооны системд тусгах санал дэвшүүлсэн.

“Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогыг 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд НХБ-ын 4, 5 болон 6 дугаар зорилтын үйл ажиллагаанууд сайн тусгагдсан байна.

11 3.2.2. байгалийн нөөцийн үндэсний парк, байгаль, соёлын өвийн дурсгалт газарт уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхлэхийг хязгаарлан, ногоон хөгжлийн жишиг нутаг болгон эко аялал жуулчлал, уламжлалт мал аж ахуйг хөгжүүлэх;

12 3.2.6. хувиргасан амьд организмын хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд үзүүлэх эрсдэлийг үнэлж, урьдчилан сэргийлэх чадавхыг бэхжүүлж, импорт, худалдааны хязгаарлалт тогтоох;

13 3.2.8. ойжуулах ажлыг эрчимжүүлж, ойгоор бүрхэгдсэн талбайг 2030 онд нийт газар нутгийн 9 хувьд хүргэж, нүүрсхүчлийн хийн шингээлтийг нэмэгдүүлэх;

14 “Байгаль орчны стратегийн үнэлгээ” гэж улс, бүс нутаг, салбарын хэмжээнд хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөний байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндэд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бодлого боловсруулах явцын эхэн үед тодорхойлох үйл явц юм.

Шалгуур үзүүлэлт

НХБ-ын 2020, 2030 хүртэлх 52 үйл ажиллагааны хэрэгжилтийг үнэлэх 14 шалгуур үзүүлэлтүүдийг “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын 958 үйл ажиллагааны хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтүүдтэй харьцуулав. Үр дүнд НХБ-ын 14 шалгуур

үзүүлэлтийн 8 нь хангалттай сайн, 1 нь хангалттай бус, 3 нь хангалтгүй, 2 нь “Алсын хараа-2050” огт тусгагдаагүй байна

2 бодлогын шалгуур үзүүлэлтүүдийг агуулгаар нь авч үзэхэд нийт 4 үзүүлэлт зөрүүтэй байдлаар тодорхойлогдсон байна.

Хүснэгт 3. Зөрүүтэй байдлаар тодорхойлогдсон шалгуур үзүүлэлтүүд

№	Ногоон хөгжлийн бодлогын шалгуур үзүүлэлт	“Алсын хараа-2050”-ын шалгуур үзүүлэлт	Нийцлийн хувь
1	Эрчим хүчний суурилагдсан хүчин чадалд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувь	Цахилгаан эрчим хүчээр хангагдсан хүн амын эзлэх хувь	Хангалтгүй
2	Ногоон хөгжилд зарцуулах зардлын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	Засгийн газрын ногоон худалдан авалтын эзлэх хувь 10%	Хангалтгүй
3	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх хувь		Хангалтгүй
4	Дотоодын нийт бүтээгдэхүүнд хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хувь	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл технологийн шинээр байгуулагдах паркийн тоо	Хангалтгүй

Source: Authors' comparison

Хэдийгээр хүснэгт 3-т харуулсан зарим шалгуур үзүүлэлтүүд зөрүүтэй тодорхойлогдсон боловч НХБ-ын шалгуур үзүүлэлтүүд “Алсын хараа-2050”-д хангалттай тусгагдсан байна. НХБ-ын зорилго хангалттай сайн, стратеги зорилтууд хангалттай байдлаар “Алсын хараа-2050”-д тусгагджээ.

“Алсын хараа-2050” урт хугацааны бодлогын баримт бичигт хүлэмжийн хий багатай үйлдвэрлэл, байгальд ээлтэй техник технологи нэвтрүүлэх, үр ашиг, бүтээмжийг дээшлүүлэх, эрчим хүчний сэргээгдэх болон бусад шинэ эх үүсвэрийг өргөнөөр ашиглах ногоон төслүүд, үйл ажиллагааг эдийн хэрэгжүүлэхээр тусгасан нь ногоон хөгжлийн асуудлыг эдийн засгийн бүх салбаруудад хэрэгжүүлэх боломж олгосон давуу талтай байна.

2.3.2. Тогтвортой хөгжлийн зорилтууд

НХБ-ын зорилго, стратегийн зорилтууд, хэрэгжүүлэхээр төлөвлөсөн үйл ажиллагаа болон шалгуур үзүүлэлтийг ТХЗ-ууд болон түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагаатай харьцуулав. НХБ-ын зорилго, зорилт, үйл ажиллагаа, шалгуур үзүүлэлтүүд нь харьцуулж буй ТХЗ-д хэрхэн

тусгагдсаныг бид нийцлийн хувь хэмээх үзүүлэлтээр илэрхийлсэн. Нийцлийн хувь өндөртэй буюу хангалттай сайн, хангалттай тусгагдсан зорилт, үйл ажиллагааг бус хангалттай бус, хангалтгүй болон огт тусгагдаагүй заалтуудыг энэхүү тайланд дэлгэрүүлэн тайлбарлаж орууллаа.

Стратегийн зорилтууд

Тогтвортой хөгжлийн 16 зорилгыг НХБ-ын стратегийн 6 зорилттой харьцуулахад нийцлийн хувь хангалттай сайн байв. ТХЗ-ын далай тэнгисийн нөөцийг хамгаалах тухай 14 дүгээр зорилго нь манай улсад төдийлөн хамаарахгүй тул харьцуулалтад оруулаагүй болно. Нийцлийн хувь хангалттай сайн байгаа нь манай улс НХБ-ыг дэлхийн нийтээр даган мөрдөж байгаа тогтвортой хөгжлийн зорилгуудтай маш сайн уялдуулж, үндэсний онцлогт тохируулан нарийвчлан задалж баталсныг илэрхийлж байна.

Тухайлбал, НХБ-ын нэгдүгээр стратегийн зорилтод тусгагдсан “Байгалийн нөөцийн хэмнэлттэй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай үйлдвэрлэл, хэрэглээг хөгжүүлнэ” гэдэг нь ТХЗ 12-р зорилгод “Хариуцлагатай хэрэглээг дэмжих” болон ТХЗ 13-р зорилгод “Цаг уурын өөрчлөлтийн талаарх арга

хэмжээг үндэсний бодлого, стратеги, төлөвлөлтөд тусгах” гэж зааснаар хангагдана гэж үзлээ. Уг заалтын хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтэд хүнсний үйлдвэрлэлийг бууруулахгүйгээр хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад чиглэсэн хөгжлийг дэмжих гэдэг үзүүлэлт оруулсан нь хүлэмжийг хийг бууруулах давхар агуулгатай болохыг харуулж байна. Үүнээс бусад стратегийн зорилтуудыг тогтвортой хөгжлийн зорилгуудтай хангалттай сайн уялдуулж тодорхойлсон байна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

ТХЗ-ын хэрэгжүүлэх үйл ажиллагааг зорилго тус бүрээр НХБ-ын үйл ажиллагаатай харьцуулахад хангалттай сайн нийцэлтэй байв. Өөрөөр хэлбэл ТХЗ-уудад амжилттай хүрч чадвал НХБ-ын үйл ажиллагаанууд мөн биелэдэхээр байна. НХБ-ын хүрээнд хийгдэх үйл ажиллагаануудаас ТХЗ-ын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаануудтай төдийлөн хангалттай бус, хангалтгүй болон огт уялдаагүй үйл ажиллагаа байхгүй байлаа.

Шалгуур үзүүлэлтүүд

УСХ-ноос сонгон авсан ТХЗ-уудыг хэрэгжилтийг үнэлж болохуйц 33 шалгуур үзүүлэлтийг НХБ-ын 14 шалгуур үзүүлэлттэй харьцуулахад нийцлийн хувь хангалттай байлаа. Гэсэн хэдий ч НХБ-ын “барилгын дулааны алдагдлын бууралт, хувь, ногоон хөгжилд зарцуулах зардлын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь, засгийн газрын ногоон худалдан авалтын эзлэх хувь” гэдэг шалгуур үзүүлэлт ТХЗ-ын шалгуур үзүүлэлтэд огт тусгагдаагүй байна. Бусад 11 шалгуур үзүүлэлт нь ТХЗ-той маш сайн уялдаж байлаа.


Ийнхүү зарим шалгуур үзүүлэлт огт тусгагдаагүй байгаа хэдий ч улсын бодлого үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахдаа ТХЗ-уудыг үндэсний онцлог, хэрэгцээ, шаардлагад нийцүүлсэн байна. Тиймээс зарим шалгуур үзүүлэлтүүд шууд байдлаар ТХЗ-уудтай уялдаагүй хэдий ч өргөн утгаараа нийцэж байх боломжтой юм. ТХЗ болон НХБ-ын шалгуур үзүүлэлтүүд заавал ижил байх шаардлагагүй.

2.4. Шалгуур үзүүлэлтийн биелэлт

НХБ-ын үйл ажиллагааны хэрэгжилтийн тайланг өнгөрсөн хоёр жилийн хугацаанд БОАЖЯ-д хүргүүлж байсан боловч хэрэгжилтийн үйл явцыг УИХ-д жил бүр тайлагнаагүй байна. Мөн НХБ-ын хэрэгжилтийг 14 шалгуур үзүүлэлт тус бүрээр үнэлж олон нийтэд тараасан албан ёсны тайлан, судалгааны ажил

хийгдээгүй байна. Тус тайланд эдгээр шалгуур үзүүлэлт тус бүрийн суурь оны тоо мэдээлэл болон гүйцэтгэлийг дор авч үзлээ.

Эндээс үзэхэд 2, 6, 8 дугаар шалгуур үзүүлэлтийн суурь түвшин, явцын түвшинг тодорхойлсон эх сурвалж байхгүй, одоог хүртэл ямар аргачлалаар хэрхэн үнэлэх асуудал нь шийдвэрлэгдээгүй байна. Үүний зэрэгцээ ярилцлагад оролцогчдын зүгээс хэрэгжилтийг хэрхэн, ямар аргачлалаар, хэн үнэлэх талаар тодорхой заалтууд байхгүйг онцолж байв. 11 дүгээр шалгуур үзүүлэлт буюу “Сайжруулсан ариун цэврийн байгууламжид хамрагдах хүн амын эзлэх хувь” 2013 онд 33.2% байсан гэх боловч, үүнээс хойш энэ үзүүлэлт хэр зэрэг биелэлттэй байгааг судалсан тоо баримт, мэдээ байхгүй байна. Хүснэгт 4-т байгаа суурь оны тоон мэдээллийг гаргахдаа өөр өөр эх сурвалжийг ашигласан болно. Мөн ярилцлагын үеэр Монгол Улсад нүүрсхүчлийн давхар исэл (CO₂) Дээрх хүснэгтээс харахад мэдээлэл бүрэн гардаг



Хүснэгт 4. Монгол Улсын ногоон хөгжлийн бодлогын хэрэгжилтийн үнэлгээ: 14 шалгуур үзүүлэлтийн биелэлт

№	Ногоон хөгжлийн бодлогын шалгуур үзүүлэлт	Оурь түвшин (2013)	Биелэлт														Хүрэх түвшин		
			2014		2015		2016		2017		2018		2019		2020		2020	2030	
			Тоон утга	Эх сурвалж	Тоон утга	Эх сурвалж	Тоон утга	Эх сурвалж	Тоон утга	Эх сурвалж	Тоон утга	Эх сурвалж	Тоон утга	Эх сурвалж	Тоон утга	Эх сурвалж			
1	Эрчим хүчний суурилагдсан хүчин чадалд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувь	7.6	Азын хөгжлийн (2017) банк	7.6	(2015) УИХ			6.9	Тлейхан (2020)	11.8	Жамбаа (2018) Үндэсний хөгжлийн газар (2018)	18.1	Тлейхан (2019)	19.3	Тлейхан (2020)		20	30	
		4.5	НХБ-ын төсөл (2014.05.12)	7.50	НЭЗТТ (2018)														
		4.3	Эрдэнэцэг (2018)																
		1	Дэлхийн банк (2019)																
		0.8	(2020a) YCX	0.8	(2020) YCX	0.6	(2020a) YCX	0.9	(2020a) YCX										
2	Барилгын дулааны алдагдлын бууралт, хувь	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	20	40		
3	Хог хагдлын дахин боловсруулалтын хэмжээ, хувь	1.4	(2020a) YCX	0.5	(2020a) YCX	0.3	(2020a) YCX	8.9	(2020a) YCX	5.1	(2020a) YCX	7.2	(2020a) YCX			20	40		
		5	НХБ-ын төсөл (2014.05.12)																
		15.7	Эрдэнэцэг (2018)																
4	Ногоон хөгжилд зарцуулах зардлын ДНБ-д эзлэх хувь	0.40	*Зохиогчид	0.32	*Зохиогчид	0.29	*Зохиогчид	0.23	*Зохиогчид	0.25	*Зохиогчид	0.27	*Зохиогчид	0.39	*Зохиогчид		2	3	
		0.5	Эрдэнэцэг (2018)																
5	Шинжлэх ухаан, технологийн судалгаанд зарцуулах зардлын ДНБ-д эзлэх хувь	0.23	(2020a) YCX	0.22	(2020a) YCX	0.05	(2020a) YCX	0.04	(2020a) YCX							2	3		
		0.26	НХБ-ын төсөл (2014.05.12)																
		0.8	Эрдэнэцэг (2018)																
6	Застийн газрын ногоон худалдан авалтын эзлэх хувь	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	20	30		
7	Тусгай хамгаалалтай газар нутгийн хэмжээ, хувь	17.4	НХБ-ын төсөл (2014.05.12) Эрдэнэцэг (2018)	17.4	БОАЖЯ (2019b)	17.85	БОАЖЯ (2017)	17.85	БОАЖЯ (2017)	17.85	БОАЖЯ (2017)	17.85	БОАЖЯ (2019b)	19.8	БОАЖЯ (2019b)	21.11	Оюунгэрэл (2020)	25	30
		13.4	(2020a) YCX	13.5	(2020a) YCX	13.5	(2020a) YCX	13.5	(2020a) YCX	13.5	(2020a) YCX	16.1	YCX (2020a)						
8	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх хувь	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	20	30		

Хүснэгт 4. Монгол Улсын ногоон хөгжлийн бодлогын хэрэгжилтийн үнэлгээ: 14 шалгуур үзүүлэлтийн биелэл (Үргэлжлэл)т

№	Ногоон хөгжлийн бодлогын шалгуур үзүүлэлт	Сурь түвшин (2013)		Биелэлт												Хүрэх түвшин			
		Тоон утга	Эх сурвалж	2014		2015		2016		2017		2018		2019		2020		2030	
				Тоон утга	Эх сурвалж	Тоон утга	Эх сурвалж	Тоон утга	Эх сурвалж	Тоон утга	Эх сурвалж	Тоон утга	Эх сурвалж	Тоон утга	Эх сурвалж	Тоон утга	Эх сурвалж		
9	Нийт газар нутагт ойгоор бүрхэгдсэн талбайн эзлэх хувь	8.03	НХБ-ын төсөл (2014.05.12) Эрдэнэцэцэг (2018) БОАЖЯ (20196) БОАЖЯ	7.8	БОАЖЯ (20196)	7.9	БОАЖЯ (20196)	7.9	БОАЖЯ (20196)	7.9	БОАЖЯ (20196)	7.9	БОАЖЯ (20196)	7.96	Отгонсүрэн (2020)		8.5	9	
		9.10	(2020a) YCX	9.2	(2020a) YCX	9.2	(2020a) YCX	9.2	(2020a) YCX	9.2	(2020a) YCX	9.2	(2020a) YCX						
		68.1	(2020a) YCX			68.1	(2020c) YCX	68.1	(2020c) YCX	68.1	(2020c) YCX	86.9	(2020c) YCX				80	90	
10	Баталгаат ундны усаар хангагдах хүн амын эзлэх хувь	72.6	НХБ-ын төсөл (2014.05.12) Эрдэнэцэцэг (2018)																
		23.2	НХБ-ын төсөл (2014.05.12)																
		33.2	Эрдэнэцэцэг (2018)															40	60
11	Сайжруулсан ариун цэврийн байгууламжид хамрагдах хүн амын эзлэх хувь	27.3	(2020a) YCX																
		27.4	Эрдэнэцэцэг (2018)	21.6	(2020a) YCX	29.6	(2020a) YCX					28.4	(2020a) YCX				24	15	
		1	НХБ-ын төсөл (2014.05.12)			14.3	(NSO (2020a												
12	Улаанбаатар хот, бусад суурин газрын ногоон байгууламжийн талбайн эзлэх хувь	3.14	Эрдэнэцэцэг (2018)														15	30	
		22.1	**Зохиогчид	22.1	**Зохиогчид	21.0	**Зохиогчид	19.0	**Зохиогчид	19.3	**Зохиогчид	20.2	**Зохиогчид	20.6	**Зохиогчид				
		22.5	Эрдэнэцэцэг (2018)															28	30
13	ДНБ-д ХАА, боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хувь	41.9	(2020a) YCX	42.9	(2020a) YCX	43.8	(2020a) YCX	45.5	(2020a) YCX	45.8	(2020a) YCX	45.8	(2020a) YCX						

Тэмдэглэл:

1. Саарал өнгөөр будсан тоон утга нь бусад эх сурвалжуудаас үнэмшил илүүг харуулна (зохиогчдын үзсэнээр),
2. " – " Гэсэн тэмдэг нь тухайн шалгуур үзүүлэлтийн хувьд ямар нэгэн тоон утга байхгүй, YCX (2017)-ноос батлагдсан аргачлалд багтаагүй, мөн "Арга зүй, ойлголт, тодорхойлолт, мэдээллийн эх үүсвэр байхгүй" болохыг илтгэнэ,
3. Хүснэгтэд байгаа хоосон зай нь ямар нэгэн тоо утга олдоогүй болохыг илэрхийлнэ,
4. * 2019-2013 онд байгаль орчны сайдад хуваариалан батлагдсан төсвийн дүнг ДНБ-д харьцуулан тооцов (УИХ, 2018-2013),
5. ** YCX-ны мэдээллийн сангаас ХАА, боловсруулах үйлдвэрлэлийн хэмжээг ДНБ-д харьцуулан тооцов (YCX, 2020b).



5 (1, 4, 7, 9, 14-р), дутуу гардаг 5 (3, 5, 10, 12, 13-р), огт мэдээлэл байхгүй 4 (2, 6, 8, 11-р) шалгуур үзүүлэлт байна. Шалгуур үзүүлэлт тус бүрийн биелэлтийг тоон үзүүлэлтээр харуулахад эх сурвалжууд ялгаатай тоо баримт гаргаж байгаа нь тус бодлогын хэрэгжилтийг үнэлэхэд ярвигтай байдалд хүргэж байна. Тухайлбал, 1-р шалгуур үзүүлэлт болох “Эрчим хүчний суурилагдсан хүчин чадалд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувь”-ийн суурь түвшинг Азийн хөгжлийн банк (2017)-ны тайланд 7.6%, НХБ-ын баримт бичгийн төсөлд 4.5%, БОАЖЯ-ны ахлах мэргэжилтэн С.Эрдэнэцэцэг (2018)-ийн илтгэлд 4.3%, Дэлхийн банк (2019)-ны тайланд 1%, ҮСХ 0.8%

гэж оруулсан байна. Эдгээрээс хамгийн үнэмшилтэй нь Азийн хөгжлийн банкны тоо мэдээ болох нь дараа жилд бодит эх сурвалжийн гаргасан тоо мэдээтэй таарч байгаагаас харж болно. Энэ мэтчилэн эх сурвалж тус бүрээс хамгийн бодитой байх боломжтой тоо мэдээнд үндэслэн НХБ-ын шалгуур үзүүлэлтээс бүрэн болон хагас мэдээлэл гардаг 10 шалгуур үзүүлэлтийн биелэлтийг доорх зурагт харуулав.

16 2014 оны 5-р сарын 12-ны өдөр ажлын хэсэгт танилцуулсан


17 (2020а)-ны ногоон хөгжлийн үзүүлэлтэд

Зураг 1. Ногоон хөгжлийн бодлогын шалгуур үзүүлэлтийн биелэлт




Зураг 1. Ногоон хөгжлийн бодлогын шалгуур үзүүлэлтийн биелэлт


10-р шалгуур үзүүлэлт: Баталгаат у/усаар хангагдах хүн амын хувь




12-р шалгуур үзүүлэлт: Ядуурлын түвшин, хувь



13-р шалгуур үзүүлэлт: УБ, суурин газрын ногоон/б-ийн эзлэх хувь



14-р шалгуур үзүүлэлт: ДНБ-д ХАА, бол/үйлдвэрлэлийн эзлэх хувь



Эх сурвалж: Хүснэт 4-ийн эх сурвалжийг ашиглан зохиогчдын тооцоолол.

Графикаас харахад тооцоололд ашиглаж болох 10 шалгуур үзүүлэлтийн 7 нь 2020 оны зорилтод түвшний 70-с илүү хувийг хангасан бол 4 шалгуур үзүүлэлт 90-с илүү хувийг биелүүлсэн байна.¹⁸

- Баталгаат ундны усаар хангагдах хүн амын хувь 2018 онд 86.9%-д хүрснээр 2020 оны хүрэх түвшинг давсан,
- Эрчим хүчний суурилагдсан хүчин чадалд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувь 2019 онд 19.3%-д хүрснээр 2020 онд хүрэх түвшинтэй харьцуулахад 96.5%-ийн хэрэгжилттэй,

- Улаанбаатар хот, бусад суурин газрын ногоон байгууламжийн талбайн эзлэх хувь 2016 онд 14.3%-д хүрснээр 2020 онд хүрэх түвшинтэй харьцуулахад 95%-ийн хэрэгжилттэй байна.
- Нийт газар нутагт ойгоор бүрхэгдсэн талбайн эзлэх хувь 2020 онд хүрэх түвшинтэй харьцуулахад 90 гаруй хувийн хэрэгжилттэй байна.

¹⁸ Сэргээгдэх эрчи хүчний эзлэх хувь, тусгай хамгаалалттай газрын эзлэх хувь, баталгаат ундны усаар хангагдах хүн амын хувь, ядуурлын түвшин, Улаанбаатар, суурин газрын ногоон байгууламжийн эзлэх хувь, ДНБ-д ХАА болон үйлдвэрлэлийн эзлэх хувь

Харин 2020 онд хүрэх түвшинтэй харьцуулахад хамгийн бага хэрэгжилттэй байгаа 3 шалгуур үзүүлэлтийг авч үзье. Үүнд:

- Шинжлэх ухаан, технологийн судалгаанд зарцуулах зардлын ДНБ-д эзлэх хувь 2016 онд 0.04% байсан нь 2020 онд хүрэх түвшинтэй харьцуулахад 2%-ийн биелэлттэй,
- Ногоон хөгжилд зарцуулах зардлын ДНБ-д эзлэх хувь 0.39% байсан нь 2020 оны хүрэх түвшинтэй харьцуулахад 19.3%-ийн хэрэгжилттэй,
- Хог хаягдлын дахин боловсруулалтын хувь 7.2%-д хүрсэн нь 2020 оны хүрэх түвшинтэй харьцуулахад 36%-ийн хэрэгжилттэй байна.



3. Дүгнэлт, зөвлөмж

ТНХБ-ыг УИХ-аар 2014 онд баталсан нь олон улсын байгууллагын өмнө хүлээсэн үүрэг, зорилгын дагуу ногоон хөгжлийн суурийг тавьж, ногоон эдийн засагт шилжих хүсэл эрмэлзэлтэй байгаагаа нотлон харуулсан үйл явдал болсон. Үүний дараагаар дэлхий нийтийн хүртээмжтэй, ногоон эдийн засгийн чиг хандлагатай уялдан “ТХҮБ 2030”, “Алсын хараа-2050” зэрэг бодлогын баримт бичгүүд батлагдаж урьд өмнө хийгдэж байгаагүй олон үйл ажиллагаа хэрэгжүүлсэн. Тодорхой зорилго, зорилтууд болон хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг дэвшүүлснээр НХБ нь Монгол Улсын хувьд ногоон хөгжлийн түүхэн үйл явдал болсон. Түүнчлэн НХБ нь эдгээр урт хугацааны бодлогын баримт бичигтэй уялдаатай байхын зэрэгцээ дараа, дараагийн бодлогын баримт бичгүүдийн үндэс болсон нь харагдаж байна.

Дунд хугацааны гүйцэтгэлийг зорилтот түвшинтэй харьцуулахад тооцоололд ашиглаж болох 10 шалгуур үзүүлэлтийн 7 нь 2020 оны зорилтод түвшний 70-с илүү хувийг хангасан бол 4 шалгуур үзүүлэлт 90-с илүү хувийг биелүүлсэн байна. НХБ нь ТХЗ болон “Алсын хараа-2050” урт хугацааны бодлогын баримт бичигтэй нягт уялдаатай байна. Түүнчлэн НХБ болон “Алсын хараа-2050” бодлогын баримт бичгийн ногоон хөгжлийн асуудлыг тусгасан 6-р зорилтыг нэг яам, газраас боловсруулан, хянах ажилд оролцсон. Стратегийн зорилт болон хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд хийсэн дүн шинжилгээ, уулзалт, ярилцлагын үеэр цуглуулсан мэдээллээс дүгнэхэд НХБ нь дараа, дараагийн бодлогын баримт бичгүүдийн үндэс болжээ. Түүнчлэн хамгийн сүүлд батлагдсан “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт эдийн засгийн бүхий л салбарт ногоон хөгжлийг тодорхой хэмжээгээр дэмжих талаар тусгасан байна.

Дунд хугацааны зарим зорилтууд биелэгдээгүй байгаа нь НХБ-ын зорилго, зорилтод хүрэхэд тодорхой хэмжээний хүндрэл бэрхшээл тулгарч байгааг харуулж байна. Тухайлбал, үйл ажиллагааны санхүүжилт хангалтгүй, оролцогч талуудын бодлогын зорилгын талаар ерөнхий ойлголт сул, хяналт үнэлгээний систем дутмаг болон зарим шалгуур үзүүлэлтүүдийг хэрхэн үнэлэх нь тодорхойгүй байна. Бодлогын хэрэгжилтийг хангах хэрэгслүүд хангалттай байгаа ч 4 шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг тооцох боломжгүй, хэрэгжилтийг хэмжих, тайлагнах нэгж тодорхойгүй хэвээр байна.

НХБ-ын хэрэгжилтийн үнэлгээ хийх явцад эдийн засгийн өсөлтийн удаашрал, ногоон хөгжилд чиглэсэн санхүүгийн урамшуулал дутмаг, оролцогч талуудын ойлголт сул, төрийн байгууллага хоорондын уялдаа сул зэрэг нийтлэг асуудлууд бодлогын хэрэгжилтэд саад болж байгаа нь ажиглагдав. Мөн ажил хариуцсан төрийн албан хаагчид сонгуулийн дараа хэт их өөрчлөгддөг нь БОАЖЯ-наас бусад яамд, агентлагууд НХБ-д хангалттай ач холбогдол өгөхгүй байгаагийн шалтгаан болж магадгүй юм. Төрийн байгууллагуудын техник, санхүү, ур чадварын чадавх сул, халаа сэлгээ их, цаашилбал НХБ, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг хариуцах эзэнгүй болох, эсвэл шинэ боловсон хүчний дахин сургах, туршлагажуулахад ихээхэн цаг хугацаа, хөрөнгө хүч шаардагддаг байна.

Бодлогын баримт бичгийн уялдаа хангалттай байгаа ч Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль (УИХ, 2020а), болон “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого (УИХ, 2020б)-той нийцүүлэн шинэчлэн найруулбал зохистой. Цаашид ҮСХ-ны ажил үүрэгт НХБ-ын шалгуур үзүүлэлтийг хэмжих ажлыг хүлээлгэн өгч, хөндлөнгийн хараат бус үнэлгээ хийхэд тохиромжтой байдлаар мэдээллийг эмхтгэн цуглуулж, ил тод байлгах шаардлагатай.

Ногоон эдийн засгийн бодлогын дүн шинжилгээнээс харахад ногоон эдийн засагт оруулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлснээр ногоон ажлын байрыг бий болгож улмаар 2030 он гэхэд ядуурлын түвшинг бууруулах юм (ЭЗБӨЧСТ, 2018 он). МУЗГ-ын тэргүүлэх чиглэлүүдийн нэг болох ядуурлыг бууруулахын зэрэгцээ эдийн засгийн өсөлтийг хангах НХБ-ын зорилтыг хэрэгжүүлэх нь нийгэм, эдийн засгийн хувьд эерэг үр өгөөж авчирна. Мөн НХБ болон ТХЗ-ыг хэрэгжүүлснээр Монгол Улсын өрсөлдөх чадвар үлэмж сайжрах тул ногоон хөгжилд зарцуулах ДНБ-ий хэмжээг нэмэх, үүнээс ногоон хөгжилтэй холбоотойгоор шинжлэх ухаан, технологид хөрөнгө оруулалт хийвэл зохистой. Түлхүүр зорилтуудаа тодорхойлон хэрэгжүүлж ажиллавал 2020 онд биелээгүй хүрэх үр дүнг 2030 онд нөхөж биелүүлэх боломжтой.

Сонгуулийн дараа шинээр байгуулагдсан ЗГ-ын албан хаагчдад НХБ-ын зорилго, зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө болон үйл явцын талаарх мэдээллээр хангаж, оролцогч талуудын хооронд нэгдсэн ойлголтыг бий болгох нь чухал юм. Бодлогын хэрэгжилтийг хариуцсан төрийн байгууллагуудын нэгдсэн зохион байгуулалтыг бэхжүүлснээр бодлогын

хэрэгжилт сайжирна гэж үзэж байна. Эдгээр бэрхшээлүүдийг даван туулахын тулд БОАЖЯ-ны эрх мэдлийг нэмэгдүүлэх, мөн Ерөнхий сайдын манлайлал чухал үүрэгтэй. Нэгдсэн удирдлага дор хамтарсан ажлын хэсэг байгуулж, бодлогын хэрэгжилтийг тогтмол тайлагнадаг байх.

НХБ-ын нэгдүгээр үе шат хэрэгжих явцад төрийн байгууллагуудын үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөөнд ногоон хөгжлийн үзэл санаа шингэж эхэлсэн байна. Цаашид энэ асуудлыг төрийн албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтод оруулж өгөх шаардлагатай. Албан тушаал ахих, шагнал урамшуулалд тодорхойлох үзүүлэлтэд ногоон эдийн засагт шилжих зорилгод нийцсэн чиг үүргүүдийг тусгаж өгөх нь үр дүнтэй.

Мөн төр, хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх шаардлагатай. Банкны салбартай хамтран ажиллаж буй сайн жишгээр барилга, аялал жуулчлал, хүнс, хөдөө аж ахуйн салбартай хамтрах шаардлагатай байна. Тухайлбал, ногоон барилгын стандарт бий болгох ажил эхэлсэн боловч анхны төслийг Архитекторуудын холбоо дэмжээгүйн улмаас зогсонги байдалд орсон. Үүнээс гадна уул уурхай, аж үйлдвэр, боловсруулах үйлдвэр, барилга, худалдаа зэрэг эдийн засгийн салбар бүрд ногоон стандартуудыг баталснаар энэ талын ойлголтыг нэгтгэж, дагаж мөрдөх дүрмийг тодорхой болгох шаардлагатай.

Бодлогын хэрэгжилтийг хангахад тогтвортой хэрэглээ болон үйлдвэрлэлийг дэмжих хандлагыг бий болгох

нь чухал юм. Ингэхдээ ногоон хөгжлийн боловсролыг иргэд, аж ахуйн нэгжүүдэд олгох, хүмүүст зөв ойлголт өгөх, улмаар иргэдийн хандлагыг өөрчлөх нь НХБ-ын хэрэгжилтийг сайжруулах үйл ажиллагааны нэг хэлбэр юм. Цаашдаа аймгуудыг нэгтгэсэн арга зүйн зөвлөмжөөр хангах чуулга уулзалтуудыг зохион байгуулах, эдийн засгийн чиглэлээр судалгаа хийдэг тинк танкуудын судлах чадавхыг идэвхжүүлэх, ногоон хөгжлийн бодлогын хэрэгжилтийн үйл явцыг УИХ-д тайлагнах, НХБ-ын зорилго, зорилтыг олон нийтэд таниулах, ногоон боловсролыг дэмжих шаардлагатай.

Зөвлөлдөх уулзалтын үеэр НХБ-ын стратегийн зорилтуудын талаар оролцогчдоос ирүүлсэн санал, сэтгэгдлийг хавсралт 5.5-д тусгав.

НХБ нь Тогтвортой хөгжлийн зорилгод хүрэх гол хэрэгсэл хэдий ч Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой нийцүүлэн шинэчлэн найруулах шаардлагатай байна. Бодлогын өөрчлөлтийг даган гарах журам, тогтоолууд нь одоо хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагаанд нөлөөлөх магадлалтай тул шинэчлэн сайжруулахдаа болгоомжтой хандах нь зүйтэй. НХБ-ын дагуу 2020-2024 оны МУЗГ-ын үйл ажиллагааны төлөвлөгөө, олон улсын байгууллагуудтай хамтран ажиллагаа, төр, хувийн хэвшлийн түншлэл, аймгуудын ногоон хөгжлийн санаачилга зэргийг цогцоор нь авч үзэх ёстой.

4. Ашигласан материалын жагсаалт

Азийн хөгжлийн банк (2017) Монгол Улс 2017–2020: “Эдийн засгийн хүндрэлийн үед хүртээмжтэй өсөлтийг хангах нь”, <https://www.adb.org/sites/default/files/institutional-document/321731/cps-mon-2017-2020-mn.pdf>,

Баянхонгор аймгийн Засаг даргын тамгын газар Байгаль орчин, аялал жуулчлалын газар (2018) “Баянхонгор аймгийн Ногоон хөгжлийн хэтийн зорилт – 2028”

БОАЖЯ (2017) “НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн хүрээний конвенцын хүрээнд Монгол Улсын хоёр жил тутмын шинэчилсэн тайлан”

БОАЖЯ (2017) Монгол орны байгаль орчны төлөв байдлын тайлан 2015-2016 он, <http://www.mne.mn/wp-content/uploads/2017/09/Tailan-pdf-last-1-ilovepdf-compressed-ilovepdf-compressed.pdf>,

БОАЖЯ (2018) “НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн хүрээний конвенцын хүрээнд Монгол Улсын уур амьсгалын өөрчлөлтийн гурав дахь харилцаа холбооны тайлан

БОАЖЯ (2019а) “Агаар бохирдуулах бодисын хаягдлын тооллого хийх аргачлал”

БОАЖЯ (2019б) Монгол орны байгаль орчны төлөв байдлын тайлан 2017-2018 он, инфографик танилцуулга, ISBN: 978-9919-21-396-1, http://www.mne.mn/wp-content/uploads/2019/08/Tuluv-Baidal-Tailan-2017-2018-Infographic_2.pdf.

БОАЖЯ (2021). Байгаль орчны мэдээллийн сан, <https://eic.mn/>

БОАЖЯ-ны сайдын багц, УИХ (2012-2018), 2013 – 2019 оны төсвийн тухай хууль,

Булган аймгийн ИТХ (2015) Булган аймгийн Ногоон хөгжлийн хэтийн зорилт 2016-2024,

Дэлхийн банк (2019) Монгол Улс:Цогц дүн шинжилгээ, Албан бус орчуулга, <http://documents1.worldbank.org/curated/en/783221547224823305/pdf/132637-MONGOLIAN-Mongolia-SCD-new-final-version-November-2018%D0%9C%D0%9E%D0%9D%D0%93%D0%9E%D0%9B-20190111.pdf>,

Жамбаа, Л. (2018) Сэргээгдэх эрчим хүчний зохицуулалт, Эрчим хүчний зохицуулах хороо <http://www.jcm-mongolia.com/wp-content/uploads/2015/10/Jambaa.pdf>,

МУЗГ (2019), “Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийн тайлан”, 2018 оны жилийн эцсийн байдлаар”

НҮБ-ын БОХ (2017) НЭЗТТ-ын хүрээнд “Ногоон эдийн засгийн явцын хэмжилтийн хүрээний хэрэгжилт, дэлхий дахинаа ядуурлыг арилган нэгдсэн хөгжил дэвшилд хүрэхэд чиглэсэн улс орнуудын явцыг үнэлэх нь”

НҮБ-ын БОХ (2020) “Хүртээмжтэй, ногоон эдийн засагт шилжих нь – Бодлогын үнэлгээний гарын авлага”

НЭЗТТ (2017), Ногоон эдийн засгийн үйл ажиллагааны үнэлгээний аргачлал, https://www.un-page.org/files/public/ger_methodology.pdf.

НЭЗТТ (2018) Ногоон эдийн засгийн бодлогын дүн шинжилгээ, https://www.greengrowthknowledge.org/sites/default/files/gepa_mon.pdf,

Орхон аймгийн ИТХ (2018) Орхон аймаг, Орхон аймгийн Ногоон, тогтвортой хөгжлийн хэтийн зорилт – 2025,

Отгонсүрэн, Б. (2020) 2019 оны нийт газар нутгийн 7.96%-ийг ойгоор бүрхэгдсэн талбай эзэлж байна, ярилцлага, өмнө нь хэвлэгдээгүй тоо мэдээ

Оюунгэрэл, Б. (2020) 2020 оны 7-р сарын 06-ны байдлаар нийт газар нутгийн 21,11%-ийг улсын ТХГН эзэлж байна, ярилцлага, өмнө нь хэвлэгдээгүй тоо мэдээ

- С.Бенсон. (2011), "Зудын гамшгийн хариу арга хэмжээ, санхүүжилт". Дэлхийн Банк, Вашингтон
- Тлейхан, А. (2019) Бага зардлаар богино хугацаанд эрчим хүчний суурилагдсан хүчин чадлаа нэмэгдүүлэх боломж бий <http://www.arслан.mn/social/news/607964.shtml>,
- Тлейхан, А. (2020) УХүрэлсүхийн засгийн газар эрчим хүчний хэрэглээгээ дотоодын эх үүсвэрээр хангах талаар түүхэн шийдвэр гаргасан, <http://erc.gov.mn/web/mn/print/410?date=true>,
- УИХ (2016), Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө 2016-2030 <https://www.legalinfo.mn/annex/details/7279?lawid=11886>
- УИХ (2011), Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр (NAPCC) <https://policy.asiapacificenergy.org/node/2721>
- УИХ (2014) Ногоон хөгжлийн бодлого, 2014 оны 6-р сарын 13-ны өдрийн 43-р тогтоол, <https://www.legalinfo.mn/annex/details/6438?lawid=10482>,
- УИХ (2015а) Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай, 2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр батлагдсан, <https://www.legalinfo.mn/law/details/11484>,
- УИХ (2015б) Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлого /2015-2030/, УИХ-ын 2015 оны 63 дугаар тогтоолын хавсралт, <https://www.legalinfo.mn/annex/details/6812?lawid=11130>,
- УИХ (2016) "Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал - 2030", 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор батлагдсан, 2020 оны 5-р сарын 13-ны өдөр хүчингүй болсон, <https://www.legalinfo.mn/law/details/11725>,
- УИХ (2020с), 'Монгол Улсын засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр', <https://www.legalinfo.mn/law/details/15586>.
- УИХ (2020а) Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль /шинэчилсэн найруулга/, 2020 оны 05 сарын 07 өдөр, <https://www.legalinfo.mn/law/details/15403?lawid=15403>,
- УИХ (2020б) "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, <https://www.legalinfo.mn/annex/details/11057?lawid=15406>,
- Үндэсний хөгжлийн газар (2018) Монгол Улсын хөгжлийн бодлогын уялдаа холбоонд үнэлгээ хийх, бодлогын хүрэх түвшинг тодорхойлох арга зүй (тайлан ii), <http://nda.gov.mn/backend/f/tailan2.pdf>,
- ҮСХ (2016) ТХЗ-ын шалгуур үзүүлэлтүүд, <https://sdg.1212.mn>
- ҮСХ (2017) Ногоон хөгжлийн үндсэн үзүүлэлтүүд түүнийг тооцох аргачлал, 2017.07.03-ны өдрийн А/103-р тушаалын хавсралт,
- ҮСХ (2017а) ТХЗ-ын хяналтын самбар, <http://sdg.gov.mn/Home/Availability>.
- ҮСХ (2020б) Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, <https://www.1212.mn/>
- ҮСХ (2020в) Монгол Улсын тогтвортой хөгжлийн зорилт <http://sdg.gov.mn/Goal?id=6>
- ҮСХ (2021а) Монгол Улсын тогтвортой хөгжлийн зорилт, ТХЗ-ын хяналтын самбар, <http://sdg.gov.mn/Home/DataList>,
- ҮСХ (2021а) Статистикийн нэгдсэн мэдээллийн сан, <http://1212.mn/>.
- ҮСХ (2021б) Монгол Улсын тогтвортой хөгжлийн зорилт, <http://sdg.gov.mn/>
- ҮСХ (2021в) Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030-ын үр дүнг илэрхийлэх үндсэн үзүүлэлтүүд, https://sdg.1212.mn/Home/SDV_indicator.
- ҮСХ, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр (2015) Joint Review of National Data Availability for SDGs

Ховд аймгийн Ногоон хөгжлийн хөтөлбөр (2016) Ховд аймгийн Ногоон хөгжлийн хэтийн зорилт 2016-2026,

Хэнтий аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар Хэнтий аймгийн Ногоон хөгжилд суурилсан тогтвортой хөгжлийн хэтийн зорилт -2026,

Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв (2018) Монгол Улсын ногоон эдийн засгийн барометр 2018, http://resource4.sodonsolution.org/nogoonhutuch/NhFile/2018/08/30/me6go46mw56pa01x/Barometer_mon_August_23.pdf

Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв (2018) Монгол Улсын ногоон эдийн засгийн бодлогын үнэлгээ 2018, http://resource4.sodonsolution.org/nogoonhutuch/NhFile/2020/04/13/vw21ndg0jk0x82bj/gepa_mon.pdf

Эрдэнэцэцэг, С. (2018) Монгол Улсын байгаль орчин, ногоон хөгжлийн бодлого, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, <http://event.oshmi.mn/wp-content/uploads/2018/01/%D0%98%D0%BB%D1%82%D0%B3%D1%8D%D0%BB-6.-%D0%AD%D1%80%D0%B4%D1%8D%D0%BD%D1%8D%D1%86%D1%8D%D1%86%D1%8D%D0%B3.pdf>,

5. Хавсралт

5.1. Ярилцсан хүмүүсийн жагсаалт

Хүснэгт 5. Ярилцсан хүмүүсийн жагсаалт

#	Байгууллага	Албан тушаал
1	БОУАС	НҮБУАӨСК Үндэсний төлөөлөгч
2	ГОУХАН: Биотархалтын төсөл	Төслийн удирдагч
3	ГОУХАН: Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх төсөл	Эксперт
4	БОАЖЯ	Ногоон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга
5	Уул уурхайн яам	Геологи, уул уурхайн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Уул уурхайн хэлтсийн дарга
6	Зам, тээврийн хөгжлийн яам	Бодлого төлөвлөлтийн газар, Стандарт нормативын хэлтсийн дарга
7	Монголын Хог Хаягдлыг Дахин Боловсруулах Үндэсний Холбоо ТББ	Гүйцэтгэх захирал
8	Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим	Мэргэжилтэн
9	Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв	Захирал
10	Үндэсний хөгжлийн газар	Судалгаа шинжилгээний газрын дарга
11	Үндэсний статистикийн хороо	Дарга
12	МУИС	Багш
13	Барилга, хот байгуулалтын яамны Бодлого, төлөвлөлтийн газар	Ахлах мэргэжилтэн
14	ХААИС ЭЗБС	Багш
15	МУИС-ийн Тогтвортой хөгжлийн хүрээлэн	Захирал
16	МУИС-ийн Тогтвортой хөгжлийн хүрээлэн	Судлаач
17	ТоС ТББ	УЗ-ийн гишүүн

Жич: : Эрчим хүчний яаманд удаа дараа ярилцлага хийх хүсэлт тавьж, алба бичиг хүргүүлсэн боловч уулзалтын цаг гаргаагүй болно.

5.2. Уншиж танилцсан баримт бичгийн жагсаалт

- Монгол Улсын засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр (УИХ-ын 45 дугаар тогтоол, 2016 он)
- Монгол Улсын Ногоон хөгжлийн бодлого (УИХ-ын 43 дүгээр тогтоол, 2014 он)
- Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль (2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр, УИХ)
- Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030 (УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоол, 2020 онд хүчингүй болсон)
- "Алсын хараа-2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого (УИХ-ын 52 дугаар тогтоол, 2020 он)
- "Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан",

- "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам" (Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоол, 2018 оны жилийн эцсийн байдлаар)
- "Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан", "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам" (Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоол, 2019 оны жилийн эцсийн байдлаар)
- Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого (УИХ-ын 18 дугаар тогтоол, 2014 он)
- Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого (УИХ-ын 62 дугаар тогтоол, 2015 он)

5.3. Тогтвортой хөгжлийн зорилгын биелэлт

Хүснэгт 6. Тогтвортой хөгжлийн зорилгын биелэлт

#	Үзүүлэлтийн нэр	Тогтвортой хөгжлийн зорилгын үзүүлэлтийн уялдаа	Хүрэх үр дүн			
			2016	2017	2020	2030
ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД						
1	Эрчим хүчний багтаамж, гж/сая төгрөг	7.3.1	9.9	-	-	-
2	Эрчим хүчний суурилагдсан хүчин чадалд сэргээгдэх эх үүсвэрийн хүчин чадлын эзлэх хувь	7.2.1	0.9	-	20	30
3	Гол нэр төрлийн эрдэс бүтээгдэхүүний боловсруулалтын хувь	8.4.1	-	-	-	-
	Нүүрс		6.9	13		
	Зэс		1	1.1		
4	Дотоодын нийт бүтээгдэхүүнд хөдөө аж ахуйн салбарын эзлэх хувь	9.2.1	11.5	10.6	28	30
5	Дотоодын нийт бүтээгдэхүүнд аж үйлдвэрийн салбарын эзлэх хувь	9.2.1	36.6	39.4		
6	Дотоодын нийт бүтээгдэхүүнд аялал жуулчлалын салбарын эзлэх хувь	8.9.1	0.2	-	-	-
7	Дотоодын нийт бүтээгдэхүүнд ногоон хөгжил болон орчныг хамгаалах зардлын эзлэх хувь	-	-	-	2	3
8	Засгийн газрын зардалд гамшгаас урьдчилан сэргийлэхэд зарцуулсан зардлын эзлэх хувь	1.5.1	-	-	-	-
9	Дотоодын нийт бүтээгдэхүүнд шинжилгээ, судалгаа, хөгжлийн зардлын эзлэх хувь	9.5.1	0.04	-	2	3

Хүснэгт 6. Тогтвортой хөгжлийн зорилгын биелэлт

#	Үзүүлэлтийн нэр	Тогтвортой хөгжлийн зорилгын үзүүлэлтийн уялдаа	Хүрэх үр дүн			
			2016	2017	2020	2030
НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД						
9	Ажилгүйдлийн түвшин, хувь	8.5.2	10	8.8	-	-
10	Хөдөлмөрийн бүтээмж, 2010 оны зэрэгцүүлэх үнээр, мян.төг	8.2.1	13281.7	12977.7	-	-
11	Ядуурлын хамралтын хүрээ буюу ядуурлын түвшин, хувь	1.1.1	29.6	-	24	15
12	Ундны баталгаат ус хэрэглэдэг хүн амын нийт суурин хүн амд эзлэх хувь	6.1.1	-	-	80	90
13	Сайжруулсан ариун цэврийн байгууламж хэрэглэдэг хүн амын нийт суурин хүн амд эзлэх хувь	7.5.2 / 6.1.2	-	-	40	60
14	Эрүүл, аюулгүй амьдралын индекс (Улаанбаатар хот)	-	-	-	-	-
БАЙГАЛЬ ОРЧНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮД						
15	Дотоодын нийт бүтээгдэхүүний нэг нэгжид ногдох материалын дотоодын хэрэглээ буюу материал багтаамж1, кг/сая.тн	12.2.1	7887	-	-	-
16	Хүлэмжийн хийн ялгарал, мян.тн	-	-	-	-	-
17	Цэнгэг усны нөөцийн гол мөрний урсац бүрэлдэх эхийн талбайд эзлэх хувь	-	-	-	-	-
18	Бохирдсон нийт усанд стандартын шаардлагад нийцсэн түвшинд цэвэршүүлсэн усны эзлэх хувь	6.3.1	96.9	-	-	-
19	Хотын агаар дахь тоосонцрын агууламж PM10, мг/м3	11.6.2	0.199	0.115	-	-
	Хотын агаар дахь тоосонцрын агууламж PM2.5, мг/м3		0.065	0.059	-	-
20	Хог хаягдлын дахин боловсруулалтын хувь	12.5.1	16.1	13.9	20	40
21	Улаанбаатар хотын ногоон байгууламжийн талбайн эзлэх хувь	11.7.1	14.3	-	15	30
22	Монгол улсын нийт газар нутагт тусгай хамгаалалттай газрын эзлэх хувь	15.4.1	13.5	13.5	25	30
23	Монгол улсын газар нутагт ойгоор бүрхэгдсэн газрын эзлэх хувь	15.1.1	9.2	9.2	8.5	9
24	Монгол улсын нийт газар нутагт хохирол учирсан талбайн эзлэх хувь	15.3.1	4.5	7.3	-	-
25	Хохирол учирсан нийт талбайд нөхөн сэргээсэн хөдөө аж ахуйн газрын эзлэх хувь	2.4.1	4.5	-	-	-
26	Хохирол учирсан нийт талбайд ашигт малтмалын олборлолтод өртсөн талбайн эзлэх хувь	2.4.1	0.1	0.1	-	-
27	Тариалангийн нийт талбайд цомхтгосон болон тэг элдэншүүлэг (боловсруулсан) хийсэн талбайн эзлэх хувь	2.4.1	-	-	-	-
28	Нийт аж ахуйн нэгжид байгаль орчны удирдлагын ISO-14002 стандартыг нэвтрүүлсэн аж ахуйн нэгжийн эзлэх хувь	12.6.1	0.0004	-	-	-

Хүснэгт 6. Тогтвортой хөгжлийн зорилгын биелэлт

#	Үзүүлэлтийн нэр	Тогтвортой хөгжлийн зорилгын үзүүлэлтийн уялдаа	Хүрэх үр дүн			
			2016	2017	2020	2030
29	Хотын агаар дахь хүхэрлэг хийн агууламж, мг/м3	-	8.4	10.3	-	-
30	Хотын агаар дахь азотын давхар ислийн агууламж, мг/м3	-		-	-	-
31	Бэлчээрийн даац, бэлчээрийн 100 мянган га-д ногдох хонин толгойгоор	-	92	99	-	-
32	Хотын агаар дахь хүхэрлэг хийн агууламж, мг/м3	-	0.027	0.02	-	-
33	Хотын агаар дахь азотын давхар ислийн агууламж, мг/м3	-	0.043	0.048	-	-

Эх сурвалж: YCX, https://sdg.1212.mn/Home/Green_development_indicator

5.4. “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” бодлогын биелэлт

Хүснэгт 7. “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” урт хугацааны хугацааны хөгжлийн баримт бичгийн биелэлт

#	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2014 (суурь түвшин)	2015	2016	2017	2030 (зорилтот түвшин)	Эх сурвалж
1	Эдийн засгийн жилийн дундаж өсөлт	хувь	7.9	2.4	1.2	5.1	6.6	Үндэсний статистикийн хороо
2	Нэг хүнд ногдох үндэсний нийт орлого	ам. доллар	4,181	3,791.0	3,465.3	3,196.8	17,500	Үндэсний статистикийн хороо
3	Хүний хөгжлийн үзүүлэлт	эзлэх байр	90	92	-		70	НҮБХХ
4	Дундаж наслалт	жил	69.6	69.89	69.57	69.89	78.0	Үндэсний статистикийн хороо
5	Ядуурлын түвшин	хувь	21.6	-	29.6	-	0	Үндэсний статистикийн хороо
6	Өрсөлдөх чадварын үзүүлэлт	эзлэх байр	104	102	101		70	Дэлхийн эдийн засгийн форум
7	Бизнес эрхлэлтийн үзүүлэлт	эзлэх байр	56	64	62		40	Дэлхийн банк
8	Байгаль орчны багц үзүүлэлт	эзлэх байр	111	-	114		90	Йелийн Их сургууль

Хүснэгт 7. “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” урт хугацааны хугацааны хөгжлийн баримт бичгийн биелэлт

#	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2014 (суурь түвшин)	2015	2016	2017	2030 (зорилтот түвшин)	Эх сурвалж
9	Эдийн засгийн идэвхтэй хүн амын нийгмийн даатгалд хамрагдсан байдал	хувь	84.4	-	-	-	99.0	-
10	Орлогын тэгш бус байдлын үзүүлэлт	оноо	36.5	-	-	-	30.0	-
11	1,000 амьд төрөлтөд нялхсын эндэгдлийн түвшин	хувийн жин	15.1	15	17	14	8.0	Эрүүл мэндийн яам
12	100,000 амьд төрөлтөд эхийн эндэгдлийн түвшин	хувийн жин	30.6	26	49	27	15.0	Эрүүл мэндийн яам
13	Ерөнхий боловсролын сургуулийн анги дүүргэлт (улсын дундаж)	тоо	27.3	27.8	27.0	28.3	20.0	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам
14	Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагын хорио, цээрийн шаардлагад нийцсэн газар нутгийн эзлэх хэмжээ	хувь	0.0	0.0	0.0	0.0	60.0	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
15	Цөлжилтөд өртсөн газар нутгийн эзлэх хэмжээ	хувь	78.2	76.8	-	-	68.0	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
16	Тусгай хамгаалалтад авсан газар нутгийн хэмжээ	хувь	13.5	13.5	13.5	13.5	30.0	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
17	Монгол Улсад аялах гадаад жуулчдын тоо	мян.хүн	392.8	386.2	404.2	496.3	2,000.0	Хил хамгаалахын ерөнхий газар
18	Цахилгаан эрчим хүчний найдвартай эх үүсвэрээр хангагдсан өрх	хувь	89.0	99.2	99.2	99.1	100.0	Үндэсний статистикийн хороо
19	Нийт экспортод боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хэмжээ	хувь	17.0	17.5	-	-	50.0	Үндэсний статистикийн хороо
20	Гол нэр төрлийн шатахууны хэрэгцээг дотоодын эх үүсвэрээс хангах хувь	хувь	0.0	0.0	0.0	0.0	100.0	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам

Эх сурвалж: YCX, 2021 https://sdg.1212.mn/Home/SDV_indicator

5.5. “Ногоон хөгжлийн бодлогын хэрэгжилт” хэлэлцүүлгийн үеэр гарсан санал

Хүснэгт 8. Ногоон хөгжлийн бодлогын хэрэгжилт хэлэлцүүлгийн үеэр гарсан санал

GD Policy Strategic objectives	Suggestions from the workshop participants
Стратегийн зорилт 2: Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэн орчны бохирдол, доройтлыг бууруулж, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгална.	- Шалгуур үзүүлэлтийг дүгнэхэд дийлэнх хувь биелэгдээгүй тул хэрэгжүүлэх механизм, шалгуур үзүүлэлт бий болгох - Үйл ажиллагааны биелэлтэд мониторинг хийх, дахин төлөвлөх - Компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт хийх ажлыг уул уурхай болон томоохон компани, аж ахуйн нэгжүүдтэй хийх
Стратегийн зорилт 3: Ногоон эдийн засгийг дэмжих санхүүжилт, татвар, зээл, урамшууллын оновчтой хөшүүргийг нэвтрүүлж, байгаль хамгаалал, хүний хөгжил, цэвэр технологийг дэмжих хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.	- Ногоон эдийн засаг нь өртөг өндөр байдаг. Эко машиныг дэмжсэнтэй адил¹⁹ үйлдвэрлэлийн ачааллыг хуваалцах - Ногоон жижиг төсөл, бизнесийг дэмжих - Иргэдийн ногоон ажлын байрыг дэмжих, үндэсний үйлдвэрлэлд түлхэц үзүүлэх - Хэрэглэгчдийн боловсрол болон бэлэн байдалд анхаарах - Урамшуулал (татварын хөнгөлөлтийг бүрэн боловсруулж, торгууль гаргаад хувийн хэвшлээ татан оролцуулах - Ногоон ажлын байрны цалинг өндөр байлгах - Үр дүнг үнэлэх хэмжүүрийг тодорхой болгох - Улс төрийн бодлогын тогтвортой байдлыг хангах - Эко – Натурал гэсэн ойлголтыг брэнд болгох
Стратегийн зорилт 4: Ногоон ажил эрхлэлтийг дэмжиж, ядуурлыг бууруулан ногоон амьдралын хэв маягийг төлөвшүүлнэ.	Хүмүүсийн хандлагыг өөрчлөх арга хэмжээ авах
Стратегийн зорилт 5: Байгальд зохицсон ахуй, соёлын үнэт зүйлсийг хөгжүүлж, боловсрол, шинжлэх ухаан, технологи, инновацийг ногоон хөгжлийн хурдасгуур болгоно	
Стратегийн зорилт 6: Уур амьсгалын өөрчлөлт, бүс нутгийн байгалийн нөөц баялаг, сэргэх чадавхад нийцүүлэн хүн амын суурьшлыг төлөвлөн хөгжүүлнэ	- Хүн амын орон нутаг дахь суурьшлыг тогтворжуулахын тулд орон нутгийн хөгжлийг дэмжсэн үйл ажиллагаа явуулах - Хүн амын өсөлтийг дэмжих, үйлдвэрлэлт, орон нутгийн ажлын байрыг нэмэгдүүлэх, ногоон боловсрол дэмжих

¹⁹ Онцгой албан татварын тухай хуулийн 7.2-т заасны дагуу “Хос тэжээлт автомашин, шингэрүүлсэн хийгээр ажилладаг автомашин, цахилгаан тэжээлт автомашины онцгой албан татварыг 50 хувиар хөнгөлнө.”<https://www.legalinfo.mn/additional/details/3080?lawid=434>

